



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ЯАМ



НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА
БАЙГАЛЬ ОРЧНЫ ХӨТӨЛБӨР



ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА




“УУР АМЬСГАЛ, ЦЭВЭР АГААРЫН
ЭВСЭЛ”



“ЦАГААН УУЛЫН ОРГИЛ” ХХК
Байгаль орчны зөвлөх үйлчилгээ

ГИДРОФТОРТ НҮҮРСТӨРӨГЧ(ГФН)-ИЙН ТӨРЛИЙН ХӨРГӨХ БОДИСЫН ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ТООЛЛОГО БОЛОН ДЭЛХИЙН ДУЛААРАЛД НӨЛӨӨЛӨХ ЧАДВАР БАГАТАЙ ОРЛУУЛАХ БОДИСЫГ НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Хамрагдсан хугацаа:2012-2015 он



Улаанбаатар хот
2016-2017 он



**CLIMATE &
CLEAN AIR
COALITION**
TO REDUCE SHORT-LIVED
CLIMATE POLLUTANTS



**ГИДРОФТОРТ НҮҮРСТӨРӨГЧИЙН ТӨРЛИЙН ХӨРГӨХ БОДИСЫН
ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ТООЛЛОГО БОЛОН ДЭЛХИЙН ДУЛААРАЛД
НӨЛӨӨЛӨХ ЧАДВАР БАГАТАЙ ОРЛУУЛАХ БОДИСЫГ НЭВТРҮҮЛЭХ
БОЛОМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ
АЖЛЫН ТАЙЛАН
2012-2015**

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Озоны үндэсний алба
Үндэсний зөвлөх “Цагаан Уулын Оргил” ХХК

Монгол Улс,
Улаанбаатар хот
2016-2017 он

**ГИДРОФТОРТ НҮҮРСТӨРӨГЧИЙН ТӨРЛИЙН ХӨРГӨХ БОДИСЫН
ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ТООЛЛОГО БОЛОН ДЭЛХИЙН ДУЛААРАЛД
НӨЛӨӨЛӨХ ЧАДВАР БАГАТАЙ ОРЛУУЛАХ БОДИСЫГ НЭВТРҮҮЛЭХ
БОЛОМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Хамрагдсан хугацаа: 2012-2015 он

Боловсруулсан:

Ц.Адьяасүрэн, проф, БОАЖЯ-ны Озоны үндэсний албаны захирал

Д.Дуламсүрэн, БОАЖЯ-ны Озоны үндэсний албаны ахлах мэргэжилтэн

Д.Энхжаргал, БОАЖЯ-ны Озоны үндэсний албаны мэргэжилтэн

Ц.Мөнхбат, “Цагаан Уулын Оргил” ХХ-ийн зөвлөх

Н.Ялалт, “Цагаан Уулын Оргил” ХХК-ийн ахлах ажилтан

Б.Отгонсүрэн, “Цагаан Уулын Оргил” ХХК-ийн ажилтан

Зөвлөхүүд:

Андрью Ейл, НҮБ-ын БОХ-ын зөвлөх

Ж.Балжинням, ШУТИС-ийн Биотехнологийн сургуулийн багш

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	5
Хүснэгтийн жагсаалт.....	6
Зургийн жагсаалт.....	8
Хураангуй.....	9
1. Танилцуулга	16
1.1. Оршил	16
1.2. Монреалийн протокол	17
1.3. Судалгааны ажлын хамрах хүрээ, зорилго	17
1.4. Арга, аргачлал	18
1.5. Судалгааны ажлын үе шат.....	20
1.5.1. Судалгааны эхний үе шат: /Удирдлага зохион байгуулалтын түвшинд/.....	20
1.5.2. Судалгааны дунд үе шат: /Суурин болон газар дээрх судалгааны түвшинд/ 21	
1.5.2.1. Суурин судалгаа.....	21
1.5.2.2. Газар дээрх судалгаа	22
1.5.2.3. Суурин болон газар дээрх судалгааны ажлын үр дүн:	23
1.5.2.4. Дүн шинжилгээ.....	24
1.5.3. Судалгааны эцсийн үе шатанд:	25
2. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импорт болон Монгол Улсын хэрэглээний ерөнхий төлөв байдал	26
2.1. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай бусад орлуулах бодисуудын импорт	26
2.2. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисууд агуулсан тоног төхөөрөмжүүдийн импортын мэдээ	32
2.3. Монгол Улс дахь ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний ерөнхий төлөв байдал.....	33
3. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын 2012-2015 оны хэрэглээ.....	39
3.1. Танилцуулга.....	39
3.2. Монгол Улсад 2012-2015 онд импортлогдон ашиглагдаж буй тоног төхөөрөмж дэхь ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээ.....	39
3.2.1. Хөргөлтийн салбар	39
3.2.1.1. Ахуйн хөргөлт	39
3.2.1.2. Худалдааны хөргөлт	40
3.2.1.3. Томоохон хөргөлтийн системүүд	41
3.2.1.4. Үйлдвэрийн хөргөлт	41
3.2.1.5. Хөргөлттэй тээвэр	42
3.2.2. Агааржуулалтын салбар	42
3.2.2.1. Суурин агааржуулагч.....	42
3.2.2.2. Автомашины агааржуулалт	43
3.2.3. Хөөсөнцрийн салбар	43

3.2.4. Уусгагчийн салбар	44
3.2.5. Аерозолын салбар.....	45
3.2.6. Гал унтраах хэрэгслүүд.....	46
3.3. Монгол Улсад импортлогдон ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ (дахин цэнэглэлт)-нд зарцуулагдсан бодисын хэрэглээ	47
3.4. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC) болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын нийт хэрэглээ	49
4. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээний өсөлт.....	56
4.1. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээний өсөлт	56
4.2. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээнээс ялгарах CO ₂ -н экв хэмжээ	60
5. Олон төрлийн хэрэглээнд ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудыг нэвтрүүлэхэд гарах бэрхшээл ба боломжууд.....	61
6. Дүгнэлт	62
Хавсралт 1. Статистикийн ерөнхий газраас хүссэн мэдээллүүд.....	62
Хавсралт 2. ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис импортлогч ААНБ	63
Хавсралт 3. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал	66
Хавсралт 4. Хүн амын өсөлт	66
Хавсралт 5. Уур амьсгалын өөрчлөлт	66
Хавсралт 6. Импортлогчид, хэрэглэгч ААНБ-ын хэрэглээний өсөлтийн талаарх асуулгын дүн	67
Хавсралт 7. ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний өсөлтийг салбар тус бүрээр нь тооцсон байдал	69
Хавсралт 8. ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний өсөлтөөс ялгарах CO ₂ -н экв хэмжээ /дэлгэрэнгүй/.....	74
Хавсралт 9. Тооллого, судалгааны үр дүнг оролцогч талуудад танилцуулсан талаар...	75
Хавсралт 10. Оролцогч талуудын уулзалтын хөтөлбөр	77
Хавсралт 11. Оролцогчдын жагсаалт	78

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

SSFA	Small-Scale funding agreement
DME	Диметил эфир
ОУ	Олон улс
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
БОХ	Байгаль орчны хөтөлбөр
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
ОУА	Озоны үндэсний алба
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ГТЕГ	Гааль, татварын ерөнхий газар
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
УУЯ	Уул уурхайн яам
АҮЯ	Аж үйлдвэрийн яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
НОБГ	Нийслэлийн Онцгой байдлын газар
ЗТЯ - ЗЦГ	Зам тээврийн яам – Замын цагдаагийн газар
УБСЕГ	Улсын бүртгэл статистикийн ерөнхий газар
МБМҮХ	Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо
МЦХ ХК	Монголын цахилгаан холбоо ХК
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
МХИТХ	Монголын хөргөлтийн инженер техникчдийн холбоо
ЭХБУТ	Эрчим хүч, барилга угсралтын трест
ОЗБ	Озон задалдаг бодис
ГФН	Гидрофторт нүүрстөрөгч
ХФН	Хлорфторт нүүрстөрөгч
ГХФН	Гидрохлорфторт нүүрстөрөгч
НУ	Нүүрс устөрөгч
ДДНЧ	Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар
ХРС	Полистирол шахмал хавтан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын 2030 он хүртэлх хэрэглээний өсөлтийн төлвийг тооцсон аргачлал..	20
Хүснэгт 1.2. Төрийн байгууллагуудын үүрэг, оролцооны байдал	23
Хүснэгт 1.3. Суурин судалгаанд хамрагдсан ААНБ-ууд	24
Хүснэгт 1.4. Дүн шинжилгээ хийсэн аргачлал	24
Хүснэгт 2.1. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай бусад орлуулах бодисуудын импортын хэмжээ, тн	27
Хүснэгт 2.2. ГФН (HFC)-ийн төрлийн хольц бодисууд дахь дан бодисын хэмжээг тооцож HFC-134a болон HFC-152a бодисуудтай нэгтгэн илэрхийлсэн байдал, тн	28
Хүснэгт 2.3. Бодисын хэрэглээний зориулалт	29
Хүснэгт 2.4. Импортлогч ААНБ-уудын импортлосон бодисын төрөл.....	30
Хүснэгт 2.5. Бодис нийлүүлэгч улс орнууд, бодисуудын төрлөөр, тн	31
Хүснэгт 2.6. 2012-2015 онд импортлогдсон хөргөлт агааржуулалтын салбарын тоног төхөөрөмжийн тоо	32
Хүснэгт 2.7. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний салбар	34
Хүснэгт 2.8. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис агуулсан тоног төхөөрөмжийг ашиглаж буй салбар ба дэд салбарууд.....	35
Хүснэгт 2.9. Дэд салбаруудад ашиглаж байгаа тоног төхөөрөмжид агуулагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын төрөл	36
Хүснэгт 2.10. Монгол Улсын 21 аймгийн хэрэглээний дэд салбарууд	37
Хүснэгт 2.11. Монгол Улсын 21 аймгийн хэмжээнд ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний салбарууд	38
Хүснэгт 3.1. Ахуйн хөргөлтөнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/	40
Хүснэгт 3.2. Худалдааны хөргөлтөнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/	40
Хүснэгт 3.3. Томоохон хөргөлтийн системд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/	41
Хүснэгт 3.4. Үйлдвэрийн хөргөлтөнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/	41
Хүснэгт 3.5. Хөргөлттэй тээвэрт ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/	42
Хүснэгт 3.6. Суурин агааржуулалтын хөргөлтөнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/	42
Хүснэгт 3.7. Автомашины агааржуулалтын хөргөлтөнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/	43
Хүснэгт 3.8. Хөөсөнцрийн үйлдвэрүүдийн жагсаалт, ашигладаг бодисуудын нэр, төрөл	43
Хүснэгт 3.9. Хөөсөнцрийн салбарт ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/	44
Хүснэгт 3.10. Уусгагч хэрэглэж буй газруудын жагсаалт, ашигладаг бодисуудын төрөл.....	44
Хүснэгт 3.11. Уусгагчийн салбарт ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/	44
Хүснэгт 3.12. MDI импортлогчид болон MDI-д агуулагдаж буй HFC-134a бодисын агууламж	45
Хүснэгт 3.13. Аерозолын салбарт ашиглагдаж буй бодисуудын хэрэглээ, тн /2012-2015/	45
Хүснэгт 3.14. Гал унтраах хэрэгсэл импортлогч ААНБ-ууд, ашигладаг бодисын нэр, төрөл	46
Хүснэгт 3.15. Гал унтраах зориулалтаар ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/	46

Хүснэгт 3.16. Монгол Улсад импортлогдон ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ (дахин цэнэглэлт)-нд зарцуулагдсан бодисын хэрэглээ	47
Хүснэгт 3.17. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын 2012-2015 оны нийт хэрэглээ, нийт CO ₂ экв тн хэмжээ/салбар болон бодисын төрлөөр/	49
Хүснэгт 3.18. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын нийт хэрэглээ, он тус бүрээр /салбар болон бодисын төрлөөр/	50
Хүснэгт 3.19. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын нийт хэрэглээ, он тус бүрээр /бодисын төрлөөр/	51
Хүснэгт 3.20. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын 2012-2015 оны нийт хэрэглээ, нийт CO ₂ экв тн хэмжээ (нэгтгэсэн дүн).....	52
Хүснэгт 3.21.Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-ийн төрлийн дан болон хольц бодисуудын CO ₂ экв хэмжээ, тн /2012-2015/	55
Хүснэгт 4.1. ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний өсөлт	56
Хүснэгт 4.2. ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээний өсөлт, тн /салбараар/	59
Хүснэгт 4.3. ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээнээс ялгарах CO ₂ -н экв хэмжээ /тн/	60
Хүснэгт 5.1. Бэрхшээл, бэрхшээлийг шийдвэрлэх арга зам.....	61

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Тооллогод хамрагдсан аймгууд	22
Зураг 2.1. ГФН (HFC)-ийн төрлийн дан болон хольц бодисуудын	27
Зураг 2.2. ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис /НУ-ийн төрлийн ба байгалийн хөргөх бодис/-уудын импортын хэмжээ, тн /2012-2015/	28
Зураг 2.3. ГФН (HFC)-ийн төрлийн бодис импортлогч гол ААНБ-ууд, импортлосон бодисын хэмжээ, тн-оор	29
Зураг 2.4. ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис импортлогч гол ААНБ-ууд, импортлосон бодисын хэмжээ, тн-оор	30
Зураг 2.5. Бодис нийлүүлэгч улс орнууд, %-иар	31
Зураг 2.6. Нийт импортлогдсон тоног төхөөрөмжийн тоо,	32
Зураг 3.1. Монгол Улсад ашиглагдаж буй нийт ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын CO ₂ экв хэмжээ, тн /2012-2015/	52
Зураг 3.2. ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудын хэрэглээ, тн /2012–2015/	53
Зураг 3.3. ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээ, тн /2012-2015/	53
Зураг 3.4. ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудын хэрэглээ, салбараар, тн	54
Зураг 4.1. ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудын хэрэглээний өсөлт	57
Зураг 4.2. ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний өсөлт	58
Зураг 4.3. ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээнээс ялгарах CO ₂ -н экв хэмжээ, тн /2012-2030/	60

ХУРААНГУЙ

Уур амьсгал, цэвэр агаарын эвсэл (CCAC)-ийн захиалгаар ГФН (HFC)-ийн төрлийн хөргөх бодисын үндэсний хэмжээний тооллого болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисыг Монгол Улсад нэвтрүүлэх боломжийг тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэх бага хэмжээний санхүүжилттэй гэрээ (SSFA)-нд НҮБ-ын БОХ (UNEP), Монгол Улсын Засгийн Газар 2016 оны 1 сарын 06-ны өдөр гарын үсэг зурсан.

Энэхүү тооллого, судалгааны ажлыг БОНХАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 05 сарын 26-ны өдрийн А/185 тоот тушаалаар батлагдсан “Бүртгэл тооллого хийх тухай” удирдамжийн дагуу үндэсний зөвлөх "Цагаан Уулын Оргил" ХХК хийж гүйцэтгэв.

Монгол Улсын ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээ

Монгол Улсын хэмжээнд 2012-2015 онд ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээ 5340.21тн, үүнийг CO₂ экв тн-оор илэрхийлбэл 613225.78тн хэмжээтэй тэнцүү байна.

ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээг төрөл тус бүрээр нь авч үзвэл ГФН (HFC)-ийн төрлийн бодисоос HFC-134a бодис 91.1%, R-410A бодис 4.9%, бусад бодисууд 4%-ийг эзэлж байна.

ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисоос R-744 бодис 37.7%, R-704 бодис 59.6%, бусад бодисууд 2.7%-ийг тус тус эзэлж байна.

Бодисын нийт хэрэглээ, CO₂-ийн нийт экв хэмжээг салбар болон бодисын төрлөөр нь хүснэгт 1, 2, 3, ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын эзлэх хувийг зураг 1, 2-т үзүүлэв.

Хүснэгт 1. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын 2012-2015 оны нийт хэрэглээ (салбараар)

	Салбар	Бодис	Жил				Нийт хэрэглээ, тн
			2012	2013	2014	2015	
Хөргөлт	Гэр ахуйн хөргөлт	R-600a	2.042	3.363	1.972	1.021	8.398
		HFC-134a	4.374	3.964	3.702	1.340	13.38
		R-602	0	0.0002	0.0004	0	0.001
		R-600	0	0.0009	0.0042	0.0025	0.008
		R-413A	0	0.0001	0	0	0.0001
		R-601a	0	0.0071	0	0	0.007
	Худалдааны хөргөлт	R-600a	1.199	1.793	0.693	0.392	4.077
		HFC-134a	0.370	2.606	1.235	0.793	5.003
		R-744	34.46	25.098	727.76	1040.52	1827.84
		R-404A	6.710	0.3311	0.549	0.347	7.937
		R-410A	0	0.0005	0	0	0.001
		R-170	0	0.00077	0.00156	0.00374	0.006
		R-508B	0	0.0003	0	0.0155	0.016
		R-508A	0	0	0.00138	0	0.001
		R-507	0.00011	0	0	0.0388	0.039
		R-764	1.346	0	0	1.082	2.429
		R-704	297	397.14	21.38	2226.05	2941.57
		R-404A	0.308	0.0149	0.0033	0.0336	0.360
		R-717	39.292	18.81	4.180	42.218	104.50

	Томоохон хөргөлтийн системүүд	R-507	1.505	0.713	0.016	0.162	2.396
	Хөргөлттэй тээвэр	HFC-134a	0.140	0.193	0.089	0	0.423
	Үйлдвэрийн хөргөлт	HFC-134a	0	0.137	0	0	0.137
R-717		0	8.56	0	0	8.56	
Агааржуулалт	Тасалгааны агааржуулалт	R-410A	9.609	2.930	4.915	0.550	18.00
		R-407C	0	0	0.001	0.01	0.011
	Бусад агааржуулалт	R-410A	0.394	0.301	0.492	0.178	1.365
		R-407C	0.0033	0	0.0101	0.0229	0.036
		HFC-134a	0	1.954	21.21	0	23.16
	Чиллер	R-410A	0	0.024	0.204	0	0.228
R-407C		0	0	0	1.224	1.224	
	Автомашинны агааржуулалт	HFC-134a	151.38	91.70	43.44	35.15	321.66
Аерозол	Эмнэлэг	HFC-134a	0.460	0.537	0	0	0.998
Хөөсөнцөр	Полистирол шахмал хавтан	HFC-152a	0	0	3.125	0	3.125
		R-744	21.38	0	0	0	21.38
		R-290	0	0	3.5	0	3.5
		DME	0	3.125	0	0	3.125
Гал унтраах хэрэгсэл	R-744	2.98	5.73	2.97	2.57	14.26	
	HFC-125	0	1,05	0	0	1.047	
Нийт хэрэглээ, тн			574.95	570.1	841.46	3353.72	5340.21

Хөргөлтийн салбарын хэрэглээг дэд салбар бүрээр тодорхойлбол:

- Ахуйн хөргөлтөнд нийт 21.78тн бодис ашиглаж байгаагаас HFC-134a бодис 61.4%, R-600a бодис 38.5%, бусад бодис 0.1% хэмжээтэй;
- Худалдааны салбарын хөргөлтөнд нийт 4788.92тн бодис ашиглаж байгаагаас R-704 бодис 61.4%, R-744 бодис 38.17%, бусад бодис 0.43% хэмжээтэй;
- Томоохон хөргөлтийн системд R-717 бодис 97.4%, R-507 бодис 2.3%, R-404A бодис 0.36% хэмжээтэй;
- Үйлдвэрийн хөргөлтөнд HFC-134a бодис 0.13тн, R-717 бодис 8.56тн хэмжээтэй;
- Хөргөлттэй тээвэрт HFC-134a бодис 0.423тн хэмжээтэй тус тус ашиглагдаж байна.

Агааржуулалтын салбарын хэрэглээг дэд салбар бүрээр тодорхойлбол:

- Суурин агааржуулалтанд HFC-134a бодис 52.3%, R-410A бодис 44.24%, R-407C бодис 3.46% хэмжээтэй, автомашинны агааржуулалтад HFC-134a бодис 292.42тн хэмжээтэй тус тус ашиглагдаж байна.

Хөөсөнцрийн салбарын хэрэглээг тодорхойлбол полистирол шахмал хөөсөнцөр хавтан (Extruded polystyrene) үйлдвэрлэлийн салбарт 2012-2014 онуудад HFC-152a, R-290, R-744 бодисуудыг ашигласан ба 2015-2016 оны байдлаар полистирол шахмал хөөсөнцрийн үйлдвэрлэл зогсонги байдалтай байна. Мөн зарим полиуретан хавтангийн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ууд нүүрсустөрөгчийн төрлийн бодис болох R-601 /пентан/ бодисыг ашиглахаар төлөвлөж байна.

Монгол Улс HFC-134a бодисыг агуулсан ингляторын төрлийн эмийн бодисоос зөвхөн вентолин, фликсотид ингляторыг импортлодог байна.

Гал унтраах хэрэгсэлд хөргөх бодисоос R-744 бодисыг өргөнөөр хэрэглэх ба HFC-125 бодис агуулсан гал унтраах хэрэгсэл зөвхөн 2013 онд импортлогдсон байна.


Хүснэгт 2. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын 2012-2015 оны нийт хэрэглээ, нийт CO₂ экв тн хэмжээ (салбараар), 2012-2015

Хэрэглээний салбар	2012	2013	2014	2015	Нийт бодисын хэрэглээ, тн	Нийт CO ₂ экв тн
Хөргөлт	388.75	462.73	761.59	3314	4927.1	71425.54
Агааржуулалт	161.39	96.91	70.27	37.13	365.69	536276.3
Аерозол	0.46	0.54	0	0	0.998	1426.43
Хөөсөнцөр	21.38	3.13	6.63	0	31.125	420.43
Гал унтраах хэрэгсэл	2.978	6.779	2.973	2.57	15.302	3677.07
Нийт	574.95	570.1	841.46	3353.7	5340.21	613225.78


Хүснэгт 3. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын 2012-2015 оны нийт хэрэглээ, нийт CO₂ экв тн хэмжээ (бодисын төрлөөр)

№	Бодис	2012	2013	2014	2015	Нийт хэрэглээ, тн	Нийт CO ₂ экв тн
1	HFC-134a	156.72	101.09	69.676	37.283	364.77	521616.18
2	HFC-125	0	1.047	0	0	1.047	3662.82
3	HFC-152a	0	0	3.125	0	3.125	387.5
4	R-404A	7.018	0.3459	0.5523	0.3806	8.297	32538.09
5	R-407C	0.0033	0	0.0111	1.2569	1.271	2255.59
6	R-410A	10.003	3.2555	5.611	0.728	19.598	40920.12
7	R-413A	0	0.0001	0	0	0.0001	0.206
8	R-508A	0	0	0.00138	0	0.001	18.42
9	R-508B	0	0.0003	0	0.0155	0.016	211.82
10	R-507	1.505	0.713	0.016	0.201	2.435	9702.35
	Нийт	175.25	106.45	78.99	39.87	400.56	611313.1
11	R-170 /Этан/	0	0.00077	0.00156	0.00374	0.006	0.036
12	R-601a /Изо-бутан/	0	0.0071	0	0	0.007	0.178
13	R-602 /Гексан/	0	0.0002	0.0004	0	0.001	0
14	R-290 /Порпан/	0	0	3.5	0	3.5	11.55

15	R-600a /Бутан/	3.241	5.156	2.665	1.413	12.48	37.425
16	R-600 /Изо-Бутан/	0	0.0009	0.0042	0.0025	0.008	0.03
17	R-744 /Нүүрсхүчлийн диоксид/	58.822	30.828	730.73	1043.09	1863.47	1863.71
18	R-717 /Аммиак/	39.292	27.37	4.18	42.218	113.06	0
19	R-764 /Хүхрийн диоксид/	1.346	0	0	1.082	2.428	0
20	R-704 /Гелий/	297	397.14	21.38	2226.05	2941.57	0
21	DME/Диметил эфир/	0	3.125	0	0	3.125	0
Нийт		399.70	463.63	762.46	3313.86	4939.65	1912.929
Нийт, тн		574.95	570.1	841.45	3353.72	5340.21	613225.78



Зураг 1. ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудын хэрэглээ, тн /2012–2015/



Зураг 2. ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээ, тн
/2012-2015/

Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын 2030 он хүртэлх хэрэглээний өсөлт

Нийт ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудын хэрэглээ 2015 оны 39.86тн хэмжээнээс өсч 2030 онд 413.89тн болох ба жил бүр өмнөх хэрэглээнээс 10-110%-иар, харин ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээ 2030 онд 16988.9тн болох ба зарим орлуулах бодисын хувьд 20%-иар өсөх үзүүлэлттэй байна.

ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний өсөлт нь хүн амын өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, импортлогч, хэрэглэгч нарын эрэлт хэрэгцээтэй шууд хамааралтай бөгөөд судалгааны явцад авсан санал асуулгын дүнгээр бодисын хэрэглээ 2030 он хүртэл өсөх хандлагатай нь ажиглагдсан.

Хөргөлтийн салбар дахь бодис тус бүрийн өсөлтийг тооцоолбол:

- Ахуйн хөргөлтийн салбар дахь HFC- 134a бодис 2021 онд 1.45тн, R-600a бодис 2012 оны 2.04тн хэрэглээнээс 2030 онд 25.8тн;
- Худалдааны хөргөлтийн салбар дахь HFC-134a бодис 2012 оны 0.37тн хэрэглээнээс 2030 онд 38.39тн, R-600a бодис 2012 оны 1.199тн хэрэглээнээс 2030 онд 11.32тн, R-744 бодис 2013 оны 34.46тн хэрэглээнээс 2030 онд 6588.4тн, R-508B бодис 2015 оны 0.0155тн хэрэглээнээс 2030 онд 0.15тн, R-507 бодис 2015 оны 0.0388тн хэрэглээнээс 2030 онд 0.239тн, R-404a бодис 2030 онд 3.82тн, R-410A бодис 2030 онд 0.00051тн;
- Үйлдвэрийн хөргөлтийн салбар дахь HFC-134a бодис 2030 онд 0.137тн, R-717 бодис 2030 онд 8.56тн;
- Хөргөлттэй тээврийн салбар дахь HFC-134a бодис 2012 оны 0.14тн хэрэглээнээс 2030 онд 1.11тн;
- Томоохон системийн хөргөлтийн салбар дахь R-404A бодис 2012 оны 0.308тн хэрэглээнээс 2030 онд 0.549тн, R-717 бодис 2012 оны 39.29тн хэрэглээнээс 2030 онд 613.2тн. R-507 бодис 2012 оны 1.505тн хэрэглээнээс 2030 онд 2.356тн болж тус тус өсөх хандлагатай байна.

Агааржуулалтын салбар дахь бодис тус бүрийн өсөлтийг тооцоолбол:

- Тасалгааны агааржуулалтын салбар дахь R-410A бодис 2012 оны 9.609тн хэрэглээнээс 2030 онд 34.65тн, R-407C бодис 2015 оны 0.01тн хэрэглээнээс 2030 онд 0.145тн;
- Бусад агааржуулалтын салбар дахь R-410A бодис 2012 оны 0.394тн хэрэглээнээс 2030 онд 3.36тн, R-407C бодис 2012 оны 0.0033тн хэрэглээнээс 2030 онд 0.294тн, HFC-134a бодис 2014 оны 21.21тн хэрэглээнээс 2030 онд 309.68тн;
- Чиллер дэхь R-410A бодис 2013 оны 0.024тн хэрэглээнээс 2030 онд 2.9тн, R-407C бодис 2021 онд 1.3тн;
- Автомашины агааржуулалтын салбар дахь HFC-134a бодис 2021 онд 38.13тн болж тус тус өсөх хандлагатай байна.

Харин аерозолын салбар дахь HFC-134a бодис 2012 оны 0.3068тн хэрэглээнээс 2030 онд 1.84тн, гал унтраах хэрэгсэлд агуулагдах R-744 бодис 2012 оны 2.98тн хэрэглээнээс 2030 онд 47тн, HFC-152a бодис 2030 онд 12тн болж өсөх хандлагатай байна.

Хүснэгт 4. ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах
бодисуудын хэрэглээний өсөлт

Бодис	2015	2020	2025	2030
HFC-134a	37.28	171.255	243.042	351.159
HFC-125	0	1.047	1.047	1.047
HFC-152a	0	12	12	12
R-404A	0.3806	1.886	3.1275	4.369
R-407C	1.2567	1.459	1.561	1.663
R-410A	0.73	17.35	29.13	40.91
R-413A	0	0.0001	0.0001	0.0001
R-508A	0	0.00138	0.00138	0.00138
R-508B	0.01551	0.074	0.112	0.15
R-507	0.201	1.004	1.8	2.595
R-170 /Этан/	0.00374	0.0412	0.0487	0.0562
R-601a /Изо-пентан/	0	0.0071	0.0071	0.0071
R-602 /Гексан/	0	0.0016	0.0026	0.0036
R-290 /Пропан/	0	3.5	3.5	3.5
R-600a /Бутан/	1.413	17.98	27.55	37.12
R-600 /Изо-бутан/	0.0025	0.024	0.0405	0.057
R-744 /Нүүрсхүчлийн диоксид/	1043.09	2908.48	4782.63	6656.78
R-717 /Аммиак/	42.22	241.36	431.56	621.76
R-764 /Хүхрийн диоксид/	1.082	1.051		
R-704 /Гелий/	2226.05	4254.82	6960.52	9666.52
DME /Диметилэфир/	0	3.13	3.13	3.13
Нийт	3353.73	7636.47	12500.81	17402.83

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. Оршил

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ)-ын суурь конвенцид Монгол Улс 1994 онд, Киотогийн протоколд 1999 онд тус тус нэгдэн орсон. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Киотогийн протоколоор зохицуулагдах бодисуудын нэг ГФН (HFC)-ийн төрлийн хөргөх бодисууд юм. Монгол Улсын хэмжээнд ГФН (HFC)-ийн төрлийн хөргөх бодисуудыг голлон хөргөлт, агааржуулалт болон хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний салбарт ашигладаг. Хэдийгээр эдгээр бодисууд нь озон задлах чадвар багатай ч ДДНЧ (GWP) ихтэй тул энэ төрлийн бодисуудын хэт их хэрэглээ нь уур амьсгалын өөрчлөлтөнд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болдог.

Уур амьсгал, цэвэр агаарын эвсэл (CCAC)-ийн захиалгаар ГФН (HFC)-ийн төрлийн хөргөх бодисын үндэсний хэмжээний тооллого болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисыг Монгол Улсад нэвтрүүлэх боломжийг тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэх бага хэмжээний санхүүжилттэй гэрээ (SSFA)-нд НҮБ-ын БОХ (UNEP), Монгол Улсын Засгийн Газар 2016 оны 1 сарын 06-ны өдөр гарын үсэг зурсан.

Энэхүү тооллого, судалгааны ажлыг БОНХАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 05 сарын 26-ны өдрийн А/185 тоот тушаалаар батлагдсан “Бүртгэл тооллого хийх тухай” удирдамжийн дагуу хийж гүйцэтгэв.

Тооллого, судалгааны ажлын тайланг боловсруулахдаа Уур амьсгал, цэвэр агаарын эвсэл (CCAC) Олон улсын байгууллагаас гаргасан судалгааны ажлын бүтэц, НҮБ-ын БОХ болон Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан гэрээний хавсралтын дагуу 2012-2015 онд “Озон задалдаг бодис, озон задалдаг бодис агуулсан тоног төхөөрөмжийг импортлох болон “Химийн хорт болон аюултай бодисыг импортлох тусгай зөвшөөрөл”-өөр импортлосон импортын мэдээг тус тус үндэслэл болгосон.

Судалгаанд худалдааны төв, зочид буудал, эмнэлэг, кинотеатр, банк, хөргөлтийн зоорь, хими цэвэрлэгээ, хүнсний үйлдвэрт ашиглагдаж буй хөргөлтийн систем, хөргөлт /хөргөгч, хөлдөөгч, хөргүүр, хөргөх ширээ, хөргөх лангуу/, агааржуулалтын тоног төхөөрөмжүүдийг хамруулсан.

Тооллого, судалгааны ажлын үр дүнгээр ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудын хэрэглээнээс уур амьсгалын өөрчлөлтөнд үзүүлж буй нөлөөллийг (CO₂ экв тн) тооцож тайлангийн 3, 6-р бүлэгт тусгасан.

Энэхүү тооллого, судалгааны ажлыг гүйцэтгэхэд оролцсон БОНХАЖЯ, ОУА, МХЕГ, ГТЕГ, ШУТИС, ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж импортлогчид, хөдөө орон нутгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны улсын байцаагч, Байгаль орчны газрын хүрээлэн буй орчны асуудал хариуцсан мэргэжилтэн нарт болон бусад оролцогч талуудад талархал илэрхийлье.

1.2. Монреалийн протокол

Монгол Улс Венийн конвенц, Монреалийн протоколд 1996 онд нэгдсэн бөгөөд Озон задалдаг бодисын тухай Монреалийн протоколыг хэрэгжүүлэх зорилгоор озон задалдаг бодисыг бүртгэх, тооллого хийх, хяналт тавих, зөвшөөрлийн тогтолцоо бүрдүүлж, түүнийг бууруулах, удирдлагыг зохицуулах зэрэг олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Монгол Улс 2010 онд хлорфторт нүүрстөрөгч (ХФН/СFC)-ийн төрлийн бодисын импорт хэрэглээг бүрмөсөн зогсоож, Олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлсэн бөгөөд 2011 оноос эхлэн Олон талт сангийн Гүйцэтгэх хорооны 63 дахь удаагийн хурлын (63/50) шийдвэр, Монреалийн протоколын Олон талт сан болон Япон улсын Засгийн газрын санхүүжилтээр дараагийн шатны зорилт болох “Озон задалдаг болон дэлхийн дулааралд нөлөөтэй гидрохлорфторт нүүрстөрөгч (ГХФН/НСFC)-ийн төрлийн хөргөх бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах менежментийн хөтөлбөр” (HPMP)-ийг хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн хүрээнд ГХФН/НСFC хөргөх бодисын хэрэглээг 2015 онд 10%, 2020 он гэхэд 35 хувиар тус тус бууруулах, ГХФН/НСFC хөргөх бодистой холбоотой үндэсний хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг сайжруулах үүрэгтэй.

Үүнээс гадна Монгол Улс нь ГФН (HFC) болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисууд, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импорт хэрэглээнд ОЗБ, ОЗБ агуулсан тоног төхөөрөмж импортлох бүртгэл хяналтын тусгай зөвшөөрлөөр хяналт тавин ажиллаж байна.

1.3. Судалгааны ажлын хамрах хүрээ, зорилго

Энэхүү судалгааны ажил нь Монгол Улсын хэмжээнд хөргөлт, агааржуулалт, хөөсөнцрийн салбар, гал унтраах хэрэгсэлд ашиглагдаж буй ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын 2012-2015 оны хэрэглээг хамарна.

Судалгааны ажлын зорилго:

- ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын одоогийн хэрэглээг тодорхойлох
- ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээний өсөлтийг тогтоох
- Цаашид олон төрлийн хэрэглээнд ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисыг нэвтрүүлэх явцад тулгарах бэрхшээл ба боломжуудыг тодорхойлох

1.4. Арга, аргачлал

Тооллогын ажлыг хийж гүйцэтгэхдээ мэргэжлийн экспертүүдтэй хамтран Top down, Bottom Up гэсэн 2 аргыг хослуулан ашигласан бөгөөд судалгааны ажлын эхний үе шатанд ОУА, ГТЕГ-ын импортын тусгай зөвшөөрлийн мэдээнд суурин судалгаа хийхдээ Top down аргыг ашигласан. Судалгааны ажлын дараачийн үе шатанд улсын хэмжээнд ашиглагдаж буй хөргөх бодисын төрөл, тоног төхөөрөмжийн хэрэглээг тодорхойлохдоо Bottom up аргыг ашиглан эцсийн хэрэглэгчдийг газар дээр нь явж судалсан. Газар дээр нь явж ажиллах үед эзэнгүй байсан, судалгаанд хариулт өгч мэдэхгүй зэрэг шалтгаанаар тооллогод хамрагдаж чадаагүй, эсвэл ижил төстэй тоног төхөөрөмжийн бодисын нэр төрөл, тоо хэмжээг тогтоохдоо Top down аргыг хослуулан ашигласан.

Тайлангийн 2 дугаар бүлгийн 2.1, 2.2 дахь хэсэгт тусгасан ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай бусад орлуулах бодисууд, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импортын хэмжээ, хэрэглээний зориулалт, бодис нийлүүлэгч улс орнуудыг тодорхойлохдоо ГТЕГ-ын 2012-2015 оны импортын мэдээнд үндэслэсэн болно.

Эцсийн хэрэглэгчдээс санал асуулгын аргаар цуглуулсан мэдээг ашиглан салбар болон дэд салбаруудад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний байдлын ерөнхий төлвийг тодорхойлж тайлангийн 2 дугаар бүлгийн 2.3 дахь хэсэгт тусгасан.

Гааль, татварын ерөнхий газар нь Гаалийн хяналтын үйл ажиллагаанд CAIS, CEPS зэрэг бүрэн автоматжуулсан программуудыг ашигладаг тул импортын мэдээ нь бодис, тоног төхөөрөмжийн төрөл, тоо хэмжээ, хэрэглээний зориулалт, импортлогч болон нийлүүлэгч байгууллага, хувь хүний мэдээллийг дэлгэрэнгүй тусгасан цогц мэдээллийг агуулж байдаг.

Тайлангийн 3 дугаар бүлгийн 3.2.1, 3.2.2 дахь хэсэгт тусгасан хөргөлт, агааржуулалтын салбарын хэрэглээг 2012-2015 онд импортлогдсон хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжид агуулагдаж буй бодисын хэмжээгээр тодорхойлсон.

Тухайн тоног төхөөрөмжид агуулагдаж буй цэнэгийн хэмжээ, ашиглагдаж буй дэд салбарыг тодорхойлохдоо газар дээрх судалгааны үр дүнг ашиглан тодорхойлсон бөгөөд газар дээрх судалгааны явцад тодруулж чадаагүй зарим тоног төхөөрөмжийн цэнэгийн хэмжээ болон ашиглагдаж буй дэд салбарыг тухайн тоног төхөөрөмжийн марк, дугаарыг тооцож тодорхойлсон.

Тайлангийн 3.2.3-3.2.6 дахь хэсэгт туссан уусгагч, аерозол, хөөсөнцрийн салбар, гал унтраах хэрэгсэлд ашиглаж буй бодисын хэрэглээг тодорхойлохдоо Bottom Up аргыг ашиглан тухайн салбар тус бүрт ашиглаж буй бодисын төрөл, тоо хэмжээ, тухайн бодисыг сонгон хэрэглэсэн шалтгаан, цаашдын хэрэглээний өсөлт зэргийг тодруулсан. Ингэхдээ:

- Хөөсөнцрийн үйлдвэрийн салбар дахь ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээг тооцохдоо МБМҮХ-той хамтран үйлдвэрүүд дээр нь очиж, санал асуулгын аргаар хэрэглээг тодорхойлсон болно.
- Аерозолын салбарын хэрэглээг тодорхойлохдоо ЭМСЯ-тай хамтарч газар дээр нь очиж, санал асуулга авч вентолин, фликсотид нэртэй ингляторын найрлага дахь HFC-134a бодисын хэмжээг тооцсон.
- Уусгагч ашиглаж буй салбарын хэрэглээг тооцохдоо эмнэлэг, эмийн сан, эм хангах нийлүүлэх байгууллагууд, хими цэвэрлэгээний газрууд дээр очин, санал асуулга авсан болно.

Тайлангийн 3 дугаар бүлгийн 3.3 дахь хэсэгт тусгасан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ буюу дахин цэнэглэлтэнд ашиглагдсан бодисын 2012-2015 оны хэрэглээг тооцохдоо “2006. IPCC guidelines for national greenhouse gas inventory” бичиг баримтын 7-р бүлэгт тусгасан ялгарлын факторын үзүүлэлтийг ашигласан.

Тайлангийн 3 дугаар бүлгийн 3.4 дэхь хэсэгт туссан Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын нийт хэрэглээг тооцохдоо 3.2 дахь хэсэгт туссан 2012-2015 онд импортлогдон ашиглагдаж буй нийт тоног төхөөрөмж дэхь бодисын хэмжээ дээр 3.3 дахь хэсэгт туссан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ (дахин цэнэглэлт)-нд зарцуулагдсан бодисын хэмжээг нэмж тооцсон. *(Нийт хэрэглээ=импортлогдсон тоног төхөөрөмж дэхь бодисын хэмжээ+эдгээр тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд зарцуулагдсан бодисын хэмжээ).*

Салбар тус бүрт 2012-2015 онд ашиглагдсан нийт бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аар нь үржүүлж CO₂ экв тн-оор илэрхийлж тайлангийн 3.2-3.3 дахь хэсгүүдэд тусгасан.

Тайлангийн 4 дүгээр бүлэгт туссан Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын 2030 он хүртлэх хэрэглээний өсөлтийн төлвийг тооцохдоо 2012-2015 оны хэрэглээ нь шугаман хамааралтай байгаа бодисуудын өсөлтийг энгийн шугаман тэгшитгэл ашиглан тооцсон. Шугаман хамааралгүй бодисуудын өсөлтийг 2016-2021 он хүртэлх Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглалтай уялдуулан тооцсон /Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн таамаглалыг хавсралт 4-т хавсаргав/. Үлдсэн хамгийн бага хэрэглээтэй болон 2012-2015 оны хооронд зөвхөн 1 удаа импортлогдсон бодисуудын хэрэглээг 2030 он хүртэл жил бүр тогтмол байхаар тус тус тооцсон болно.

Өсөлтийг тооцсон аргачлалыг хэрэглээний салбар болон бодисуудын төрлөөр нь хамааруулан дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 1.1. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын 2030 он хүртэлх хэрэглээний өсөлтийн төлвийг тооцсон аргачлал

Хэрэглээний дэд салбарууд	Өсөлт тооцсон аргачлал, бодисын төрөл		
	Шугаман тэгшитгэл	Эдийн засаг	Тогтмол
Гэр ахуйн хөргөлт	R-600a, R-602, R-600	HFC-134a	R-413A, R-601a
Худалдааны хөргөлт	R-404A, HFC-134a, R-600a, R-744, R-170, R-508B, R-507	R-764	R-410A, R-508A
Хөргөлттэй тээвэр	HFC-134a	-	-
Үйлдвэрийн хөргөлт	-	-	HFC-134a, R-717
Томоохон хөргөлтийн систем	R-404A, R-717, R-507	-	-
Чиллер	R-410A	-	R-407C
Өрөөний агааржуулалт	R-410A, R-407C	-	-
Бусад агааржуулалт	R-410A, R-407C, HFC-134a	-	-
Автомашинны агааржуулалт	-	HFC-134a	-
Аерозол	HFC-134a	-	-
Хөөс	-	-	R-744, R-290, DME
Гал унтраах хэрэгсэл	R-744	-	HFC-125

1.5. Судалгааны ажлын үе шат

1.5.1. Судалгааны эхний үе шат: /Удирдлага зохион байгуулалтын түвшинд/

- ✓ Уур амьсгал, цэвэр агаарын эвсэл (CCAC)-ийн ГФН (HFC)-ийн төрлийн хөргөх бодисын үндэсний хэмжээний тооллого болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисыг Монгол Улсад нэвтрүүлэх боломжийг тодорхойлох судалгааны ажлын даалгавар, НҮБ-ын БОХ Монгол Улсын Засгийн Газар хооронд байгуулсан бага хэмжээний санхүүжилттэй гэрээний хавсралт 4 (Эцсийн тайлангийн бүтэц)-тай тус тус танилцсан.
- ✓ БОНХАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/184 тоот “Семинар зохион байгуулах тухай” тушаалын дагуу “ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын үндэсний хэмжээний тооллого, судалгааны ажлын тухай” сэдэвт оролцогч талуудын уулзалтыг ОУА-тай хамтран 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.
- ✓ БОНХАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/185 тоот “Бүртгэл тооллого хийх тухай” тушаалаар Тооллого, судалгааны ажлын удирдамж болон тооллого, судалгааны ажилд оролцох үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулсан.
- ✓ БОНХАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан тооллого, судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 2016 оны 06 сарын 13-ны өдөр БОНХАЖЯ дээр БОНХАЖЯ, ОУА, ГТЕГ, МХЕГ, ХХААЯ, УУЯ, АУЯ, ЗТЯ-ЗЦГ, УБСЕГ, МЦХ ХК, МБМУХолбооны төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.

- ✓ ОУА болон Үндэсний зөвлөх компаний хооронд тооллогын ажлын явц, үйл ажиллагааны талаар 6 удаа дугуй ширээний уулзалт хийсэн.
- ✓ ОУА-ны зөвлөмжийн дагуу МХЕГ-аас хөдөө орон нутагт тооллого хийхэд тухайн орон нутгийн Мэргэжлийн Хяналтын Газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарыг оролцуулж ажиллуулах тухай шийдвэр гаргуулсан.

1.5.2. Судалгааны дунд үе шат: /Суурин болон газар дээрх судалгааны түвшинд/

1.5.2.1. Суурин судалгаа

- ✓ ГТЕГ-н импортын болон ОУА-ны тусгай зөвшөөрлийн бүртгэл мэдээнээс дараах мэдээллүүдийг боловсруулсан. Үүнд:
 - Тоног төхөөрөмжийн төрөл болон хэмжээ /2012-2015/
 - Тоног төхөөрөмжид агуулагдах ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын төрөл, тэдгээрийн хэмжээ /2012-2015/
 - Гол импортлогч ААНБ-уудын мэдээ /2012-2015/
 - Гол нийлүүлэгч улс орнуудын мэдээ /2012-2015/
- ✓ Нийт 11 Төрийн байгууллага руу мэдээлэл цуглуулах зорилгоор санал асуулгын хуудас албан бичгийн хамт хүргүүлсэн. /БОНХАЖЯ, МХЕГ, ХХААЯ, УУЯ, АҮЯ, ЗТЯ, УБСЕГ, ИНЕГ, ЭМЯ, ХХЦХ, МБМҮХ/
- ✓ Импортлогч нараас ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийг ямар компаниас, хэзээ, хэр хэмжээтэйг ямар зориулалтаар авсан, яагаад тухайн бодисыг сонгосон тухай тодруулах зорилгоор дараах ААНБ-руу санал асуулгын хуудас боловсруулан хандаж мэдээлэл цуглуулсан. Үүнд:
 - Хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмж импортлогч 29 ААНБ
 - Гал унтраах хэрэгсэл импортлогч 7 ААНБ
 - MDI импортлогч 2 ААНБ
 - Химийн бодис импортлогч 38 ААНБ
- ✓ Газар дээрх судалгааны ажлын төлөвлөгөө, эцсийн хэрэглэгч нараас мэдээлэл авах зорилгоор 9 төрлийн дэлгэрэнгүй санал асуулгын хуудас тус тус бэлтгэсэн.

1.5.2.2. Газар дээрх судалгаа

2016 оны 06 сарын 08-наас ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын судалгаа, тооллогын ажлыг Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн төвийн хэмжээнд эхлүүлсэн. Газар дээрх тооллого, судалгаанд аймаг, нийслэлийн МХГ-ын улсын байцаагч нар болон зарим аймгийн байгаль орчны газрын хүрээлэн буй орчны асуудал хариуцсан мэргэжилтэн нар хамтарч оролцсон. Судалгааны баг тус бүрийн тооллого хийсэн аймгуудыг Зураг 1.1-т харуулав.



Зураг 1.1. Тооллогод хамрагдсан аймгууд

Газар дээрх судалгаанд томоохон худалдааны төв, зочид буудал, эмнэлэг, кинотеатр, банк, хөргөлттэй агуулах, хүнсний үйлдвэрүүдэд ашиглагдаж буй хөргөлтийн систем, агааржуулагч, хөргөлтийн тоног төхөөрөмж (хөргөгч, хөлдөөгч, хөргүүр, хөргөх лангуу, хөргөх шүүгээ)-үүд хамрагдсан.

1.5.2.3. Суурин болон газар дээрх судалгааны ажлын үр дүн:

Хүснэгт 1.2. Төрийн байгууллагуудын үүрэг, оролцооны байдал

№	Төрийн байгууллагууд	Үүрэг, оролцоо	Үүрэг, оролцоогоо биелүүлсэн тухай
1	БОНХАЖЯ	<ul style="list-style-type: none"> ОЗБ-той холбоотой бодлого, дүрэм журам, ОЗБ-ыг орлуулах бодисууд (химийн бодисууд)-ыг импортлох тусгай зөвшөөрөл олгосон тайлан 	Мэдээллээр хангасан.
2	МХЕГ	<ul style="list-style-type: none"> Томоохон үйлдвэрлэл, үйлчилгээний төвүүдийн жагсаалт, хөргөх бодис, тоног төхөөрөмжийн мэдээлэл Уул уурхайн компаниудын жагсаалт Химийн хорт болон аюултай бодистой холбоотой үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-ийн жагсаалт 	Мэдээллээр хангасан.
3	ХХААЯ	<ul style="list-style-type: none"> Хөргөлтийн агуулах, зоорь Худалдааны төвүүдийн мэдээлэл 	Мэдээллээр хангаагүй.
4	УУЯ	<ul style="list-style-type: none"> Уул уурхайн салбарт ашиглагдаж буй хөргөх бодис, Хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжийн хэрэглээний мэдээлэл 	Мэдээллээр хангаагүй.
5	АҮЯ	<ul style="list-style-type: none"> Хөргөх бодис ашигладаг хүнд болон хөнгөн үйлдвэрүүдийн мэдээлэл 	Мэдээллээр хангаагүй.
6	ЗТЯ	<ul style="list-style-type: none"> Автотээврийн хэрэгслийн статистик мэдээ 	Мэдээллээр хангасан.
7	УБСЕГ	<ul style="list-style-type: none"> Холбогдох ААНБ-ын статистик тоо /42/-н мэдээллээр хангах /Хавсралт 1/ 	Мэдээллээр хангасан.
8	ИНЕГ	<ul style="list-style-type: none"> Агаарын тээврийн компаниудын мэдээ 	Мэдээллээр хангаагүй.
9	ЭМЯ	<ul style="list-style-type: none"> Эмнэлэг, эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх төв тэдгээрийн эм тариа хадгалдаг агуулахууд, эмийн сан, сувилалын газрууд, цогцос хадгалах газартай эмнэлэгүүдийн мэдээ Сальбутамол аэрозоль хэлбэрийн эмийг импортлох тусгай зөвшөөрөлтэй ААН, мөн Монгол Улсад бүртгэлтэй энэ төрлийн ингаляцийн эмийн найрлага, импортлосон тоо ширхэг зэргийн мэдээ 	Мэдээллээр хангасан.
10	ХХЦХ	<ul style="list-style-type: none"> Харилцаа холбооны компаниудын хөргөх бодис, тоног төхөөрөмжийн хэрэглээтэй холбоотой мэдээлэл 	Мэдээллээр хангаагүй.
11	МБМУХолбоо	<ul style="list-style-type: none"> Барилгын материал үйлдвэрлэлийн чиг хандлага, өсөлт Холбогдох ААНБ-уудын ашиглаж буй хөргөлтийн төхөөрөмж, хөргөх бодисын талаар мэдээлэл XPS, полиуретан сэндвичэн хавтан үйлдвэрлэдэг ААНБ-уудын мэдээ 	Мэдээллээр хангаагүй.

Хүснэгт 1.3. Суурин судалгаанд хамрагдсан ААНБ-ууд

Асуулга авсан ААНБ-ын төрөл		Хэрэглээний салбар
Хэрэглэгч ААНБ-ууд	Хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээ эрхэлдэг ААНБ, иргэн	Хөргөлт, агааржуулалт
	Худалдааны төв, зах, дэлгүүр	
	Зочид буудал, кинотеатр, банк, харилцаа холбооны компаниуд, томоохон барилга байгууламжууд	
	Агуулах, зоорь	
	Эмийн сан, эм ханган нийлүүлэх төв	Хөргөлт, агааржуулалт, уусгагчид, аерозол
	Эмнэлэг	Хөөсөнцөр үйлдвэрлэл
	Хөөсөнцрийн үйлдвэрүүд	
	Автомашинны засвар үйлчилгээний газрууд	Агааржуулалт
Хими цэвэрлэгээний газрууд	Уусгагчид	

1.5.2.4. Дүн шинжилгээ

Хөргөлт, агааржуулалтын салбарын хэрэглээг ГТЕГ-ын импортын мэдээгээр, хөөсөнцөр, уусгагч, аерозолын салбар, гал унтраах хэрэгслийн хэрэглээг санал асуулгын дүнгээр тус тус тодорхойлсон. Салбар тус бүрийн хэрэглээг хэрхэн тооцсоныг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1.4. Дүн шинжилгээ хийсэн аргачлал

№	Хэрэглээний салбар	Мэдээллийн эх сурвалж	Тоног төхөөрөмжийн тоо	Хөргөх бодисын цэнэг	Тоног төхөөрөмжид ашиглагдаж буй бодисын хэрэглээ	Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ
1	Хөргөлт, агааржуулалт	ГТЕГ-ын импортын мэдээнээс дараах тоног төхөөрөмжүүдийн тоог гаргасан.	Ахуйн хөргөлт	Тоног төхөөрөмжид агуулагдах хөргөх бодисын хэмжээг тодорхойлсон	Тоног төхөөрөмжийн тоог тухайн тоног төхөөрөмжид агуулагдаж буй хөргөх бодисын цэнэгээр үржүүлсэн хэмжээ нь хэрэглээтэй тэнцүү байна.	Ялгарлын фактор буюу тухайн салбараас жилд ялгарах бодисын хэмжээг хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг ашиглан тооцсон.
			Худалдааны хөргөлт			
			Томоохон хөргөлтийн систем			
			Үйлдвэрийн хөргөлт			
			Хөргөлттэй тээвэр			
			Суурин агааржуулагч			
2	Автомашинны агааржуулалт	ЗЦГ-аас автомашины тоог авсан	Суудлын Ачааны Автобус г.м	Автомашин тус бүрт агуулагдах хөргөх бодисын хэмжээг тодорхойлсон	Агааржуулалттай авто тээврийн хэрэгслийн нийт тоонд суурилсан	

3	Хөөсөнцөр	Санал асуулгын дүн /Бүртгэлтэй хөөсөнцрийн үйлдвэрүүдийн мэдээг МБМҮХ-ноос ирүүлсэн мэдээнээс илрүүлсэн/	-	-	7 үйлдвэрлэгч компаний 2012-2015 оны хэрэглээнд суурилсан.	Ялгарлын фактор буюу тухайн салбараас жилд ялгарах бодисын хэмжээг хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг ашиглан тооцсон.
4	Уусгагч	Санал асуулгын дүн	-	-	3 Хими цэвэрлэгээний газар, 27 эмнэлэг, 17 эм ханган нийлүүлэх төв, 5 эмийн сангийн 2012-2015 оны хэрэглээнд суурилсан.	.
5	Аерозол	Санал асуулгын дүн	Инглятор	Ингляторт агуулагдах хөргөх бодисын хэмжээг тодорхойлсон	MDI импортлогч 2 ААНБ-ын 2012-2015 оны хэрэглээнд суурилсан. /Ингляторын нийт тоог тухайн ингляторт агуулагдах хөргөх бодисын цэнэгээр үржүүлсэн хэмжээ нь тус салбарын хэрэглээг илэрхийлнэ/	
6	Гал унтраах хэрэгсэл	Санал асуулгын дүн	Гал унтраагуур	Гал унтраагуурт агуулагдах хөргөх бодисын хэмжээг тодорхойлсон	Гал унтраах хэрэгсэл импортлогч 7 ААНБ-ын 2012-2015 оны хэрэглээнд суурилсан. /Гал унтраагуурын нийт тоог тухайн гал унтраагуурт агуулагдах хөргөх бодисын цэнэгээр үржүүлсэн хэмжээ нь тус салбарын хэрэглээг илэрхийлнэ/	Ялгарлын фактор буюу тухайн салбараас жилд ялгарах бодисын хэмжээг хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг ашиглан тооцсон.

1.5.3. Судалгааны эцсийн үе шатанд:

- ✓ Суурин болон газар дээр нь явж цуглуулсан мэдээллүүдийг нэгтгэн боловсруулах
- ✓ Судалгааны ажлын тайлангийн төслийг боловсруулж ОУА болон гадаадын зөвлөх экспертүүдээс санал авах
- ✓ Судалгааны ажлын үр дүнг оролцогч талуудад танилцуулах

- ✓ Судалгааны ажлын тайлан эцэслэн боловсруулж дуусгах гэсэн үе шаттайгаар ажилласан.

2. ГФН (HFC)-ҮҮД БОЛОН ДДНЧ (GWP) БАГАТАЙ ОРЛУУЛАХ БОДИС, ТЭДГЭЭРИЙГ АГУУЛСАН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ИМПОРТ БОЛОН МОНГОЛ УЛСЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай бусад орлуулах бодисуудын импорт

Монгол Улсад 2012-2015 онд 11 төрлийн нийт 4476.09тн бодис импортлогдсон бөгөөд ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудаас HFC-134a бодисыг, ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудаас R-704 бодисыг хамгийн их хэмжээтэй импортлосон байна. Бусад бодисуудын импортын хэмжээ жил бүр харилцан адилгүй байна. /Хүснэгт 2.1, Зураг 2.1-2.2/

ГФН (HFC)-ийн төрлийн HFC-134a бодисын 90% нь дан байдлаар импортлогдсон бол үлдсэн 10% нь хольц бодист агуулагдаж байна. Харин HFC-125, HFC-143a, HFC-32 бодисууд нь дан байдлаар огт импортлогддоггүй байна. /Хүснэгт 2.2/

ГФН (HFC)-ийн төрлийн дан болон хольц бодис болох HFC-134a, R-404A, R-410A, R-407C, R-507 бодисуудыг хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмж цэнэглэх зорилгоор ГФН (HFC)-ийн төрлийн бодис импортлогч томоохон 7 ААНБ, HFC-152a бодисыг XPS хөөсөнцрийн үйлдвэрлэлд ашиглах зорилгоор “Билгүүн трейд” ХХК импортлосон байна. /Хүснэгт 2.3-2.4, Зураг 2.4/

ДДНЧ (GWP) багатай бодисуудаас R-744 бодисыг хүнсний бүтээгдэхүүн, лабораторийн урвалж дээжийг хэвийн температурт хадгалахад, зарим тохиолдол XPS хөөсөнцрийн үйлдвэрлэл, ундаа хийжүүлэх, унадаг дугуй хийлэх зэрэгт, R-717 бодисыг үйлдвэрийн хөргөлтөнд, R-600a бодисыг хөргөлтийн тоног төхөөрөмжийг цэнэглэх, R-764, R-704 бодисуудыг эмнэлгийн тоног төхөөрөмж цэнэглэх зориулалтаар томоохон 5 ААНБ импортлон ашиглаж байна. ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай бодис импортлогч ААНБ-уудын дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 2-т хавсаргав. /Хүснэгт 2.3, Зураг 2.3-2.4/

ГФН (HFC)-ийн төрлийн дан болон хольц бодисуудыг ОУА-ны тусгай зөвшөөрлөөр харин бусад ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис /НУ-ийн төрлийн болон байгалийн хөргөх бодисууд/-уудыг БОНХАЖЯ-ны Химийн бодис импортлох тусгай зөвшөөрлөөр импортлодог /НУ-ийн төрлийн R-600a бодисоос бусад бодис/.


Нийт бодисын 54%-ийг БНХАУ, 35%-ийг БНСУ, 11%-ийг бусад улс орнуудаас импортлосон байна. /Хүснэгт 2.5, Зураг 2.5/

ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай бусад орлуулах бодисуудын импортын хэмжээ, бодисын зориулалт, импортлогч ААНБ, нийлүүлэгч улс орны талаарх мэдээллийг Хүснэгт 2.1-2.5, Зураг 2.1-2.5-д тус тус харууллаа.


Хүснэгт 2.1. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай бусад орлуулах бодисуудын импортын хэмжээ, тн

№	Бодис	2012	2013	2014	2015	Нийт
ГФН (HFC)-ийн төрлийн дан бодис						
1	HFC-134a	2.254	5.4	9.917	3.232	20.803
2	HFC-152a	-	-	2.5	-	2.5
ГФН (HFC)-ийн төрлийн хольц бодисууд						
3	R-404A	0.953	4.0639	1.443	1.186	7.6459
4	R-410A	0.734	0.732	2.23	3.025	6.7215
5	R-407C	0.025	0.389	1.015	1.978	3.406
6	R-507	-	0.113	-	0.723	0.8362
ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисууд						
7	R-764	1.224	-	-	0.984	2.208
8	R-744	48.429	22.8	661.49	945.687	1678.41
9	R-704	270	361.036	19.44	2023.68	2674.156
10	R-717	27	25	27	-	79
11	R-600a	0.027	0.253	0.121	-	0.401
Нийт		350.646	419.787	725.156	2980.5	4476.09

Тэмдэглэл: R-764 /Хүхрийн диоксид/, R-744 /Нүүрсхүчлийн диоксид/, R-717 /Аммиак/, R-600a /Изо-бутан/



Зураг 2.1. ГФН (HFC)-ийн төрлийн дан болон хольц бодисуудын импортын хэмжээ, тн /2012-2015/



Зураг 2.2. ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис /НУ-ийн төрлийн ба байгалийн хөргөх бодис/-уудын импортын хэмжээ, тн /2012-2015/

Хүснэгт 2.2. ГФН (HFC)-ийн төрлийн хольц бодисууд дахь дан бодисын хэмжээг тооцож HFC-134a болон HFC-152a бодисуудтай нэгтгэн илэрхийлсэн байдал, тн

№	Бодисын төрөл	Импортын хэмжээ /2012-2015/	HFC-134a	HFC-152a	HFC-125	HFC-143a	HFC-32
ГФН (HFC)-ийн төрлийн дан бодис							
1	HFC-134a	20.803	20.803				
2	HFC-152a	2.5		2.5			
ГФН (HFC)-ийн төрлийн хольц бодисууд							
3	R-404A	7.655	0.3062		3.3682	3.9806	
4	R-410A	6.721			3.3605		3.3605
5	R-407C	3.406	1.77112		0.8515		0.78338
6	R-507	0.836			0.4181	0.4181	
Нийт			22.88	2.5	7.998	4.399	4.15

Тайлбар: ГФН (HFC)-ийн төрлийн хольц бодисын найрлага дахь дан бодисуудын харьцааг тогтоохдоо ОЗБ-ыг орлуулах бодисын судалгааны ажлын гарын авлагыг ашигласан болно. (Inter-agency Coordination Meeting Montreal, 1–2 March 2016 MLF/IACM.2016/1/22 18 February 2016)

R-404A: HFC-125(44%) +HFC-143a (52%) +HFC-134a (4%)


R-410A: HFC-32(50%) + HFC-125(50%)

R-407C: HFC-32 (23%) +HFC-125(25%) +HFC-134a (52%)

R-507: HFC-125 (50%) +HFC-143a (50%)

Хүснэгт 2.3. Бодисын хэрэглээний зориулалт


Бодисын төрөл	Бодисуудын хэрэглээний зориулалт
R-410A	R-410A, R-407C – агааржуулагч, агааржуулалтын систем цэнэглэх HFC-134a, R-404A, R-600a – хөргөлтийн тоног төхөөрөмж /хөргөгч, хөлдөөгч, хөргөх лангуу, хөргөх шүүгээ, хөргөх ширээ/ цэнэглэх
HFC-134a	
R-404A	
R-407C	
R-507	
R-600a	
HFC-152a	Хөөсөнцрийн үйлдвэрлэл
R-744 (Нүүрсхүчлийн диоксид)	<ul style="list-style-type: none"> • Хөөсөнцрийн үйлдвэрлэл • Сургалт судалгааны урвалж, дээж хадгалах • Ундаа хийжүүлэх • Гүний уурхайн агаар цэвэршүүлж, шингээх • Спорт сургалтын бууны • Унадаг дугуйны дугуй хийлэх • Эмнэлэгт үр шилжүүлэн суулгах
R-704 (Гели)	<ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн лаборатори, Судалгаа шинжилгээ • MRI хүний биеийн оношлогооны томографи аппарат цэнэглэх • Тархалтын судалгааны төхөөрөмж
R-717 (Аммиак)	Үйлдвэрийн хөргөлт
R-764 (Хүхрийн диоксид)	Эмнэлгийн томографын аппаратны хөргөлт



Зураг 2.3. ГФН (HFC)-ийн төрлийн бодис импортлогч гол ААНБ-ууд, импортлосон бодисын хэмжээ, тн-оор

Хүснэгт 2.4. Импортлогч ААНБ-уудын импортлосон бодисын төрөл


ААНБ-ын нэр	Үйл ажиллагааны чиглэл	HFC-152a	R-404A	R-410A	R-407C	HFC-134a	R-507
Билгүүн трейд ХХК	Хөөсөнцрийн үйлдвэр	▼					
Синусдочи ХХК	Хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмж импортлох, худалдах		▼	▼	▼	▼	
Тулга төхөөрөмж ХХК	Нийтийн хоолны тоног төхөөрөмжийн худалдаа, угсралт, засвар үйлчилгээ		▼			▼	▼
Термотех ХХК	Хөргөлт /хөргөх хөлдөөх камер, нийтийн хоолны тоног төхөөрөмж/, агааржуулалтын тоног төхөөрөмж импортлох худалдах, угсрах, засвар үйлчилгээ хийх		▼	▼	▼		▼
Хөргөлт Сервис ХХК	Хүнсний болон тусгай зориулалтын хөргөлтийн систем, ахуйн болон төвлөрсөн эйр кондишны систем, дунд болон их оврын барилгын агааржуулалтын системийг угсарч, сэлбэг материал худалдах		▼	▼	▼	▼	
Тулга техник ХХК	Гал тогооны хөргөх , халаах, механик тоног төхөөрөмжинд техникийн бүх төрлийн засвар үйлчилгээ, угсралт					▼	
Монхор хээр ХХК	Гэр ахуйн цахилгаан барааны засвар, үйлчилгээ					▼	
Аргалант арвис групп ХХК	Эйр кондейшн, гүн хөлдөөгч, агаар сэлгэх төхөөрөмж угсралт засвар үйлчилгээ			▼			



Зураг 2.4. ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис импортлогч гол ААНБ-ууд, импортлосон бодисын хэмжээ, тн-оор

Хүснэгт 2.5. Бодис нийлүүлэгч улс орнууд, бодисуудын төрлөөр, тн

Нийлүүлэгч улс	Бодис	2012	2013	2014	2015	Нийт, тн
БНХАУ	R-764	1.08				1.08
	R-744	46.3	22.8	660.91	945.601	1675.61
	R-704	266.4	342.36			608.76
	R-717	27	25	27		79
	R-404A	0.963	4.0639	1.443	1.186	7.656
	HFC-134a	2.254	5.4	9.917	3.232	17.571
	R-407C	0.025	0.389	1.015	1.978	3.407
	R-410A	0.734	0.662	1.53	2.325	5.251
	R-507		0.113		0.723	0.836
БНСУ	R-600a	0.027	0.253	0.121		0.401
	R-704	3.6	4.8	7.2	1546.3	1561.9
	R-744	2		0.3846	0.05	2.435
	R-410A		0.07	0.7	0.7	1.47
	HFC-134a			0.004		0.004
АНУ	HFC-152a			2.5		2.5
	R-744	0.056		0.019		0.075
Япон Улс	R-764	0.144				0.144
	R-744	0.07				0.07
ХБНГУ	R-704			2.496	3.003	5.499
	R-744	0.001		0.019	0.023	0.043
Австрали	R-764				0.984	0.984
Лихтенштейн Вант улс	R-744				0.013	0.013
Тайвань	R-704		13.876	9.504	477.602	500.982
Нидерланд	R-704			0.24		0.24
Нийт хэмжээ, тн		350.646	419.787	725.156	2980.5	4476.09




Зураг 2.5. Бодис нийлүүлэгч улс орнууд, %-иар

2.2. ГФН (НФС)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисууд агуулсан тоног төхөөрөмжүүдийн импортын мэдээ

Хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжийн импортын мэдээнээс харахад 2012 онд хамгийн их буюу 91775ширхэг, 2015 онд хамгийн бага буюу 44958ширхэг, нийт 2012-2015 онд 310801ширхэг тоног төхөөрөмж импортлогдсон байна. /Хүснэгт 2.6, Зураг 2.6/

Хүснэгт 2.6. 2012-2015 онд импортлогдсон хөргөлт агааржуулалтын салбарын тоног төхөөрөмжийн тоо

Тоног төхөөрөмжийн төрөл	Хугацаа, он			
	2012 он	2013он	2014 он	2015 он
Хөргөгч, хөлдөөгч	82887	78345	77043	40353
Хөргүүр	1574	2113	708	2399
Агааржуулагч	6671	8101	5167	1143
Хөргөх лангуу	302	504	684	503
Хөргөх ширээ	69	172	494	104
Хөргөх шүүгээ	272	214	523	456
Нийт	91775	89449	84619	44958



Зураг 2.6. Нийт импортлогдсон тоног төхөөрөмжийн тоо, 2012-2015 он

2.3. Монгол Улс дахь ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний ерөнхий төлөв байдал

Хөргөлт, агааржуулалт, хөөсөнцөр болон гал унтраах хэрэгслийн салбарт ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудаас HFC-152a, HFC-134a, R-404A, R-407C, R-410A, ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудаас R-600a, R-744, R-717, R-290 бодисууд, аерозолын салбарт зөвхөн HFC-134a бодисыг ашиглаж байна. /Хүснэгт 2.7/

Нийт 16 дэд салбарт түгээмэл ашиглагдаж буй ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисууд нь HFC-134a, R-404A, R-410A, R-600a байна.

Хүнсний үйлдвэр, агуулах, зоорьд R-717 бодистой хөргөлтийн тоног төхөөрөмж, компрессорыг, харин R-744 бодистой хөргөгч, хөргүүрийг зочид буудал, худалдааны төв, зах, ресторануудад өргөнөөр ашиглаж байна. Томоохон зочид буудал, худалдааны төвүүд, кинотеатр, оффис, банкууд R-410A агуулсан агааржуулагчаас гадна HFC-134a, R-600a агуулсан хөргөгч, хөлдөөгч болон R-404A, R-744 агуулсан хөргүүр, хөргөх шүүгээ, хөргөх ширээг ашигладаг.

Үүнээс гадна эмнэлэгийн салбарт HFC-134a, R-600a, R-410A агуулсан лабораторийн зориулалттай хөргөгч, моргийн хөлдөөгч, хөргүүр, HFC-134a бодистой аерозоль хэлбэрийн эмийг ашиглаж байна. /Хүснэгт 2.9/

Хөдөө орон нутагт махны үйлдвэрүүд, мах, хүнсний ногоо хадгалах зоорь, худалдаа үйлчилгээний төвүүд, зочид буудал, зоогийн газрууд мөн эмнэлэг, эмнэлэгийн цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис болон тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж ашиглагдаж байна. /Хүснэгт 2.10/

Зарим хүн ам харьцангуй их, дэд бүтэц хөгжсөн, уул уурхай, аялал жуулчлалын үйл ажиллагаа ихтэй аймгуудад томоохон оффис, хүнсний үйлдвэрүүдэд ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис болон тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж ашиглагдаж байна. /Хүснэгт 2.10/

Монгол Улсын хэмжээнд Улаанбаатар хотоос гадна 21 аймгийн хэмжээнд зөвхөн хөргөлт, агааржуулалт, аерозолын салбарт ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудыг ашиглаж байна. /Хүснэгт 2.11/

Хүснэгт 2.7. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний салбар

Салбар	Хэрэглээний салбар	Онцлог хэрэглээ	ГФН (HFC) төрлийн бодис	ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисууд
Хөргөлт	Гэр ахуйн хөргөлт	Хөргөгч, хөлдөөгч	HFC-134a	R-600a
	Худалдааны хөргөлт	Хөргөгч, хөлдөөгч	HFC-134a	R-600a
		Хөргөх ширээ, хөргөх шүүгээ	HFC-134a, R-404A	R-600a
		Хөргүүр	HFC-134a, R-404A,	R-600a, R-744
		*Эмнэлэгийн томографны хөргөлт	-	R-764, R-704
	Томоохон хөргөлтийн системүүд	Хөргөлтийн систем	HFC-134a, R-404A,	R-717
	Үйлдвэрийн хөргөлт	Хөргөлтийн тоног төхөөрөмж	HFC-134a	R-717
	Хөргөлттэй тээвэр	Контейнер	HFC-134a, R-404A	-
Агааржуулалт	Агааржуулах тоног төхөөрөмж	Өрөөний агааржуулагч	R-407C, R-410A	-
		Бусад агааржуулалт /including split, multi-split and variable refrigerant flow systems, ducted and package rooftop/	HFC-134a, R-407C, R-410A	-
		Чиллер	R-407C, R-410A	-
	Хөдөлгөөнт агааржуулагч	Автомашин	HFC-134a	-
Хөөс		XPS, PU хөөсөнцөр үйлдвэрлэл	HFC-152a	R-290, R-744
Аэрозол		MDI импорт	HFC-134a	-
Гал унтраах хэрэгсэл		Гал унтраах хэрэгсэл	HFC-125	R-744

*-Ашиглаж буй бодисоор нь эцсийн хэрэглэгчийг тодруулсан.

Хүснэгт 2.8. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис агуулсан тоног төхөөрөмжийг ашиглаж буй салбар ба дэд салбарууд

№	Хэрэглээний салбар	№	Дэд салбар
1	Хөргөлт, агааржуулалтын салбар	1	Зочид буудал
		2	Кинотеатр
		3	Дэлгүүр, супермаркет
		4	Караоке, бар
		5	Худалдааны төв, зах
		6	Цайны газар
		7	Эмнэлэг, амралт сувиллын газар
		8	Ресторан, лоанже
		9	Оффис
		10	Фитнесс төв
		11	Банк
		12	Хүнс, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр /мах, ундаа ус, зайрмаг, гурилан бүтээгдэхүүн гэх мэт/
		13	Телевизийн байр
		14	Лаборатори
		15	Үйлдвэр
		16	Зоорь
		17	Хөргөлт агааржуулалтын засвар үйлчилгээ
		18	Сургууль
		19	Нисэх онгоцны буудал
2	Аерозолын салбар	20	Эмийн сан
		21	Эмийн үйлдвэр
		22	Эм ханган нийлүүлэх төв
		23	Эмнэлэг
3	Хөөсөнцрийн салбар	24	Хөөсөнцрийн үйлдвэр
4	Засвар үйлчилгээний салбар	25	Машин засварын газар
		26	Электрон барааны засвар үйлчилгээний газар
		27	Хөргөгч болон хөргөх төхөөрөмж засварын газар
5	Гал унтраах хэрэгслийн салбар	28	Гал унтраах хэрэгсэл импортлодог, худалдаалдаг газар

Хүснэгт 2.9. Дэд салбаруудад ашиглаж байгаа тоног төхөөрөмжид агуулагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын төрөл

№	Дэд салбар	ГФН (HFC) болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын төрөл					
		HFC-134a	R-600a	R-404A	R-410A	R-717	R-744
		Хөргөлтийн систем, хөргөгч, хөлдөөгч, *агааржуулагч	Хөргөгч, хөлдөөгч	Хөргүүр, хөргөх ширээ, хөргөх шүүгээ	Агааржуулагч	Хөргөлтийн төхөөрөмж, компрессор	Хөргөгч, хөргүүр,
1	Томоохон зочид буудал	✓	✓	✓	✓		✓
2	Жижиг зочид буудал	✓	✓				
3	Томоохон худалдааны төв	✓	✓	✓	✓		✓
4	Худалдааны зах	✓	✓				✓
5	Кинотеатр	✓	✓		✓		
6	Эмнэлэг, эмийн сан	✓	✓	✓			
7	Томоохон оффис				✓		
8	Телевиз	✓			✓		
9	Банк	✓			✓		
10	Агуулах, зоорь	✓				✓	
11	Сүлжээ ресторан	✓	✓	✓			✓
12	Хүнсний үйлдвэр					✓	
13	Цайны газар	✓	✓				
14	Мини дэлгүүр	✓	✓				
15	Сургууль	✓	✓				
16	*Авто засварын газар	✓					

Хүснэгт 2.10. Монгол Улсын 21 аймгийн хэрэглээний дэд салбарууд

№	Аймгийн нэр	Тооллогод хамрагдсан дэд салбарууд												
		Эмнэлэг	Банк	Махны үйлдвэр	Худалдаа үйлчилгээ	Зочид буудал	Зоогийн газар	Үзвэр үйлчилгээ	Томоохон оффис	Харилцаа холбооны газар	Хими цэвэрлэгээ	Засварын газар	Хүнсний үйлдвэр	Цахилгаан станц
1	Сэлэнгэ	✓		✓	✓		✓				✓	✓	✓	
2	Дархан	✓	✓	✓	✓	✓	✓		✓			✓	✓	✓
3	Орхон	✓	✓	✓		✓	✓				✓			
4	Төв	✓	✓	✓	✓			✓		✓				
5	Дундговь	✓	✓	✓	✓	✓	✓					✓		
6	Дорноговь	✓		✓	✓		✓				✓			
7	Өмнөговь	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓		✓	✓		
8	Хөвсгөл	✓		✓	✓		✓		✓					
9	Баянхонгор	✓		✓										
10	Хэнтий	✓	✓	✓	✓	✓	✓		✓					
11	Сүхбаатар	✓		✓	✓			✓						
12	Дорнод	✓		✓	✓	✓	✓					✓	✓	
13	Говь-Алтай	✓		✓										
14	Завхан	✓		✓	✓	✓	✓							
15	Архангай	✓	✓	✓	✓	✓	✓				✓			
16	Ховд	✓		✓	✓	✓	✓							
17	Увс	✓		✓	✓	✓	✓					✓		
18	Булган	✓		✓	✓	✓			✓	✓	✓			
19	Өвөрхангай	✓	✓	✓	✓	✓				✓				
20	Говьсүмбэр	✓		✓	✓		✓							
21	Баян-өлгий	✓		✓	✓	✓			✓	✓	✓	✓		
22	Улаанбаатар	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓

Хүснэгт 2.11. Монгол Улсын 21 аймгийн хэмжээнд ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний салбарууд

№	Аймгийн нэр	Хэрэглээний салбар					
		Хөргөлт	Агааржуулалт	Уусгагч	Хөөс	Аерозол	Гал унтраах хэрэгсэл
1	Сэлэнгэ	✓	✓			✓	
2	Дархан	✓	✓			✓	
3	Орхон	✓	✓			✓	
4	Төв	✓	✓			✓	
5	Дундговь	✓	✓			✓	
6	Дорноговь	✓	✓			✓	
7	Өмнөговь	✓	✓			✓	
8	Хөвсгөл	✓	✓			✓	
9	Баянхонгор	✓	✓			✓	
10	Хэнтий	✓	✓			✓	
11	Сүхбаатар	✓	✓			✓	
12	Дорнод	✓	✓			✓	
13	Говь-Алтай	✓	✓			✓	
14	Завхан	✓	✓			✓	
15	Өвөрхангай	✓	✓			✓	
16	Архангай	✓	✓			✓	
17	Ховд	✓	✓			✓	
18	Увс	✓	✓			✓	
19	Булган	✓	✓			✓	
20	Баян-өлгий	✓	✓			✓	
21	Говьсүмбэр	✓	✓			✓	
22	Улаанбаатар	✓	✓	✓	✓	✓	✓

Тэмдэглэл: Аерозол хэлбэрийн эмийг импортлодог “Монос Фарм” ХХК нь Монгол Улсын 21 аймагт үйл ажиллагаа эрхэлдэг учир бүх аймагт аерозолын салбар байна гэж үзсэн болно.

3. ГФН (HFC)-ҮҮД БОЛОН ДДНЧ (GWP) БАГАТАЙ ОРЛУУЛАХ БОДИСЫН 2012-2015 ОНЫ ХЭРЭГЛЭЭ

3.1. Танилцуулга

2012-2015 оны хооронд нийт 21 төрлийн 5340.21тн ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудыг ашигласнаас 92.3% нь хөргөлт, 6.8% нь агааржуулалт, 0.9% нь аерозол, хөөсөнцрийн салбарт болон гал унтраах хэрэгсэлд ашиглагдаж байна. Үүнийг CO₂ экв тн-оор илэрхийлбэл 613225.78тн хэмжээтэй тэнцүү байна. /Хүснэгт 3.18/

Нийт 613225.78тн CO₂ экв хэмжээг салбар тус бүрээр нь илэрхийлвэл 11.6% нь хөргөлт, 87.5% нь агааржуулалт, 0.2% нь аерозол, 0.1% нь хөөсөнцөр, 0.6% нь гал унтраах салбаруудад ашиглагдсан байна. /Зураг 3.1/

ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудын хэрэглээг бодис тус бүрээр нь илэрхийлвэл HFC-134a бодис 364.77тн буюу 91.1%, R-410A бодис 19.6тн буюу 4.9%, бусад бодисууд 16.18 тн буюу 4%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 3.2/

ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээг бодис тус бүрээр нь илэрхийлвэл R-744 бодис 1692.7тн буюу 37.7%, R-704 бодис 2674.2тн буюу 59.6%, бусад бодисууд 122.6тн буюу 2.7%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 3.3/

2012-2015 оны нийт хэрэглээнээс ГФН (HFC)-ийн төрлийн бодисууд автомашины агааржуулалтын салбарт 312.66тн буюу 80.4%, бусад агааржуулалтын салбарт 24.6тн буюу 6.1%, ахуйн хөргөлтөнд 13.4тн буюу 3.3%, худалдааны хөргөлтийн салбарт 13тн буюу 3.2%, суурин агааржуулалтад 18тн буюу 4.5% бусад салбаруудад 9.31тн буюу 2.5% хэмжээтэйгээр ашиглагдаж байна. /Зураг 3.4/

3.2. Монгол Улсад 2012-2015 онд импортлогдон ашиглагдаж буй тоног төхөөрөмж дэхь ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээ

3.2.1. Хөргөлтийн салбар

Хөргөлтийн салбар нь ахуйн, худалдааны, үйлдвэрийн, хөргөлттэй тээвэр, томоохон хөргөлтийн систем гэсэн салбаруудад хуваагдах ба доорх хүснэгтүүдэд салбар тус бүрээр хэрэглээг харуулав.

3.2.1.1. Ахуйн хөргөлт

Ахуйн хөргөлтөнд HFC-134a бодис 61.4%, R-600a бодис 38.5%, бусад бодис 0.1% хэмжээтэй ашиглагдаж байна.

Ахуйн хөргөлтийн салбарт 2012-2015 онд ашиглагдсан нийт 21.77тн бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв тн-оор илэрхийлвэл 19141.8тн хэмжээтэй тэнцүү байна. Үүний 99.8%-ийг HFC-134a бодис, 0.2%-ийг бусад төрлийн бодисууд байна.

Хүснэгт 3.1. Ахуйн хөргөлтөнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар	Бодисын төрөл	Бодисын хэмжээ /тн/					Нийт /CO ₂ экв тн/
		2012	2013	2014	2015	Нийт	
Ахуйн хөргөлт	HFC-134a	4.37	3.961	3.698	1.339	13.368	19116.24
	R-600a	2.04	3.36	1.97	1.02	8.39	25.17
	R-600	0.0009	0.0042	0.0025		0.0076	0.0304
	R-413A	-	0.0001	-	-	0.0001	0.2053
	R-602	-	0.0002	0.0004	-	0.0006	
	R-601a	-	0.0071	-	-	0.0071	0.1775
Нийт		6.41	7.33	5.67	2.36	21.77	19141.8

Тайлбар: Гэр ахуйн зориулалттай хөлдөөгчийн хэрэглээний эзлэх хувийг тодорхойлох зорилгоор цахим хэлбэрээр явуулсан асуултад 254 хүн оролцсоноос 159 буюу 62.5% нь ахуйн зориулалтаар хөргөгчнөөс гадна хөлдөөгч хэрэглэдэг гэж хариулсан тул үлдсэн 37.5%-ийг худалдаанд ашиглагдаж байна гэж үзсэн.

3.2.1.2. Худалдааны хөргөлт

Худалдааны салбарын хөргөлтөнд нийт 4353.6тн бодис ашиглаж байгаагаас R-704 бодис 61.4%, R-744 бодис 38%, бусад бодисууд 0.6% хэмжээтэй ашиглагдаж байна.

Худалдааны хөргөлтийн салбарт 2012-2015 онд ашиглагдсан нийт 4361.52тн бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв тн-оор илэрхийлвэл 36828.2тн хэмжээтэй тэнцүү байна. Үүний 76.8% нь R-404A бодис, 17.7% нь HFC-134a бодис, 5.5% нь бусад төрлийн бодисууд байна.

Хүснэгт 3.2. Худалдааны хөргөлтөнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар	Бодисын төрөл	Бодисын хэмжээ /тн/					Нийт /CO ₂ экв тн/
		2012	2013	2014	2015	Total	
Худалдааны хөргөлт	HFC-134a	0.336	2.369	1.1224	0.721	4.55	6506.5
	R-600a	1.09	1.63	0.63	0.356	3.71	11.13
	R-404A	6.1	0.301	0.499	0.315	7.215	28297.23
	R-744	31.329	22.816	661.6	945.928	1661.673	1661.67
	R-170	-	0.0007	0.00142	0.0034	0.00552	0.03312
	R-508B	-	0.0003	-	0.0141	0.0144	192.931
	R-508A	-	-	0.00125	-	0.00125	16.745
	R-507	0.0001	-	-	0.03528	0.03538	141.0
	R-410A	-	0.00046	-	-	0.00046	0.96048
	R-764	1.224			0.984	2.208	0
R-704	270	361.036	19.44	2023.68	2674.156	0	
Total		310.1	388.2	683.3	2972.0	4353.6	36828.2

3.2.1.3. Томоохон хөргөлтийн системүүд

Томоохон хөргөлтийн системд R-717 бодис 97.4%, R-507 бодис 2.2%, R-404A 0.4% хэмжээтэй ашиглагдаж байна.

Томоохон хөргөлтийн системд 2012-2015 онд ашиглагдсан нийт 97.505тн бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв тн-оор илэрхийлвэл 9961.824тн хэмжээтэй тэнцүү байна. Үүний 87% нь R-507 бодис, 13% нь R-404A бодис байна.

Хүснэгт 3.3. Томоохон хөргөлтийн системд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар	Бодисын төрөл	Бодисын хэмжээ /тн/					Нийт /CO ₂ экв тн/
		2012	2013	2014	2015	Нийт	
Томоохон хөргөлтийн системүүд	R-404A	0.28	0.0135	0.003	0.0305	0.327	1282.494
	R-717	35.72	17.1	3.8	38.38	95	0
	R-507	1.368	0.648	0.0144	0.1476	2.178	8679.33
Нийт		37.368	17.762	3.817	38.558	97.505	9961.824

3.2.1.4. Үйлдвэрийн хөргөлт

Үйлдвэрийн хөргөлтөнд HFC-134a бодис 0.13тн буюу 1.6%, R-717 бодис 8тн буюу 98.4% хэмжээтэй ашиглагдаж байна.

Үйлдвэрийн хөргөлтөнд 2012-2015 онд ашиглагдаж буй бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв-аар илэрхийлвэл 185.9тн хэмжээтэй тэнцүү HFC-134a бодис байна.

Хүснэгт 3.4. Үйлдвэрийн хөргөлтөнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар	Бодисын төрөл	Бодисын хэмжээ /тн/	Нийт /CO ₂ экв тн/
		2013	
Үйлдвэрийн хөргөлт	HFC-134a	0.13	185.9
	R-717	8	0
Нийт		8.13	185.9

Тайлбар: R-717 бодисын хувьд "Мах маркет" ХХК-ийн 1990-2010 онуудад импортлосон нийт 10 хөргөлтийн системийн 38ш компрессорт агуулагдаж буй 41тн аммиак бодисын хэрэглээг илрүүлсэн ба суурилуулсан он нь судалгааны хүрээнд хамрахгүй тул зөвхөн 2013 онд импортлосон 8тн бодисын хэмжээг хүснэгтэнд тусгав.

3.2.1.5. Хөргөлттэй тээвэр

Хөргөлттэй тээврийн салбарт 2012-2015 онд ашиглагдсан HFC-134a бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв тн-оор илэрхийлвэл нийт 526.24тн хэмжээтэй тэнцүү байна.

Хүснэгт 3.5. Хөргөлттэй тээвэрт ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар	Бодисын төрөл	Бодисын хэмжээ /тн/				Нийт /CO ₂ экв тн/
		2012	2013	2014	Нийт	
Хөргөлттэй тээвэр	HFC-134a	0.122	0.169	0.077	0.368	526.24

3.2.2. Агааржуулалтын салбар

3.2.2.1. Суурин агааржуулагч

Суурин агааржуулалтанд HFC-134a бодис 52.3%, R-410A бодис 44.24%, R-407C бодис 3.46% хэмжээтэй ашиглагдаж байна.

Суурин агааржуулалтын салбарт 2012-2015 онд ашиглагдсан нийт 43.583тн бодисуудын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв тн-оор илэрхийлвэл 75518.52тн хэмжээтэй тэнцүү байна. Үүний 49.28% нь тасалгааны агааржуулалтанд ашиглагдаж буй R-410A бодис, 43.4% бусад агааржуулалтанд ашиглагдаж буй HFC-134a бодис, үлдсэн 7.32% нь R-407C бодис байна.

Хүснэгт 3.6. Суурин агааржуулалтын хөргөлтөнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар	Бодисын төрөл	Бодисын хэмжээ /тн/					Нийт /CO ₂ экв тн/
		2012	2013	2014	2015	Нийт	
Тасалгааны агааржуулалт	R-407C	-	-	0.001	0.01	0.011	19.514
	R-410A	9.514	2.901	4.866	0.545	17.826	37220.69
Бусад агааржуулалт /including split, multi-split and variable refrigerant flow systems, ducted and package rooftop/	HFC-134a	-	1.935	21	-	22.935	32797.05
	R-407C	0.0033	-	0.01	0.0227	0.036	63.864
	R-410A	0.39	0.298	0.487	0.176	1.351	2820.888
Чиллер	R-407C		-	-	1.2	1.2	2128.8
	R-410A	-	0.024	0.2	-	0.224	467.712
Нийт		9.9073	5.158	26.564	1.9537	43.583	75518.52

3.2.2.2. Автомашины агааржуулалт

Автомашины агааржуулалтын салбарт 2012-2015 онд ашиглагдсан нийт 292.42тн HFC-134a бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв тн-оор илэрхийлвэл 418160.6тн хэмжээтэй тэнцүү байна.

Хүснэгт 3.7. Автомашины агааржуулалтын хөргөлтөнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар	Бодисын төрөл	Бодисын хэмжээ /тн/					Нийт /CO ₂ экв тн/
		2012	2013	2014	2015	Нийт	
Автомашины агааржуулалт	HFC-134a	137.62	83.36	39.49	31.95	292.42	418160.6

3.2.3. Хөөсөнцрийн салбар

Полистирол шахмал хөөсөнцөр хавтан (Extruded polystyrene) үйлдвэрлэлийн салбарт 2012-2014 онуудад HFC-152a бодис 2.5тн, R-290 бодис 2.8тн, R-744 бодис 17.1тн, DME бодис 2.5тн-г тус тус ашигласан байна. Гэвч 2015-2016 оны байдлаар полистирол шахмал хөөсөнцрийн үйлдвэрлэл зогсонги байдалтай байна.

Полиуретан хөөсөнцөр хавтангийн 5 үйлдвэр байгаагаас “ЭХБУТ” “ДБ Панел систем” ХХК-ууд үйлдвэрлэл явуулаагүй бөгөөд бусад 3 үйлдвэр нь изодиметил изоцианит, изоцианит, MDI зэрэг бодисуудыг үйлдвэрлэлдээ ашиглаж байна.

Хөөсөнцрийн салбарын 2012-2015 онд ашиглагдсан бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв-аар илэрхийлвэл 336.34тн хэмжээтэй тэнцүү байна. Үүний 92.2% нь HFC-152a бодис, 2.7% нь R-290 бодис, 5.08% нь R-744 төрлийн бодис байна.

Хүснэгт 3.8. Хөөсөнцрийн үйлдвэрүүдийн жагсаалт, ашигладаг бодисуудын нэр, төрөл

№	Хөөсөнцрийн үйлдвэрийн нэр	Үйлдвэрийн төрөл	Ашигладаг бодисын нэр, төрөл
1	“Билгүүн трейд” ХХК	Полистирол шахмал хавтан	HFC-152a, R-744
2	“Нью Ворм” ХХК	Полистирол шахмал хавтан	HFC-152a, R-290
3	Гейтвей девелопмент Монголиа ХХК	Полиуретан блок	Изодиметил изоцианит
4	“Кореа стандарт” ХХК	Полиуретан шүршигч	MDI, Polyol
5	“ДБ Панел систем” ХХК	Полиуретан хавтан	*Пентан
6	“ЭБМАТ” ХХК	Полиуретан хавтан	Polyol, isocyanate
7	“ЭХБУТ” ХХК	Полиуретан хавтан	*Пентан

*Пентан- “ЭХБУТ” ХХК болон “ДБ Панел систем” ХХК нь одоогоор үйлдвэрлэл явуулаагүй байгаа бөгөөд цаашид пентан бодисыг ашиглахаар төлөвлөж байна.

Хүснэгт 3.9. Хөөсөнцрийн салбарт ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар	Бодисын төрөл	Бодисын хэмжээ, тн					Нийт /CO ₂ экв тн/
		2012	2013	2014	2015	Нийт	
Полистирол шахмал хавтан	HFC-152a		2.5			2.5	310
	R-290			2.8		2.8	9.24
	R-744	17.1				17.1	17.1
	DME*		2.5			2.5	
Полиуретан хавтан	Изодиметил изоцианит				8.5	8.5	
	Polyol				7.82	7.82	
Полиуретан шүршигч	MDI*	79	35	45	150	309	
	Polyol	33	35	45	150	263	
Полиуретан блок	Изодиметил изоцианит		3	1	3	7	
Нийт		129.1	78	93.8	319.32	620.22	336.34

Тайлбар: *MDI-diphenylmethane diisocyanate, DME*- Dimethyl ether

3.2.4. Уусгагчийн салбар

Монгол Улсын хэмжээнд ГФН (HFC)-ийн төрлийн болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодист суурилсан ариутгал, цэвэрлэгээний уусгагч ашиглахгүй байна.

Хүснэгт 3.10. Уусгагч хэрэглэж буй газруудын жагсаалт, ашигладаг бодисуудын төрөл

№	ААНБ-ын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Ашигладаг бодисын нэр, төрөл
1	“Метро экспресс” ХХК	Хими цэвэрлэгээ, угаалгын газар	Перхлорэтилен
2	“Нарта” ХХК	Хими цэвэрлэгээ	V-3 /petroleum, hydrotreated light, kerosene/
3	“Хайтан” ХХК	Хими цэвэрлэгээ	Трихлорэтилен
4	Улсын 1, 2-р эмнэлэг, Батлан хамгаалах, хууль сахиулах албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	Эмнэлэг	Этилендиоксид

Хүснэгт 3.11. Уусгагчийн салбарт ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар		Перхлорэтилен	Трихлорэтилен	Нийт
		тн	тн	тн
Уусгагч	Хими цэвэрлэгээ	27.45	2.336	29.786
	Электроник цэвэрлэгээ	-	-	
	Нарийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ	-	-	

3.2.5. Аерозолын салбар

Аерозолын салбарт ашигласан 0.655тн HFC-134a бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв тн-оор илэрхийлвэл 950.95тн хэмжээтэй тэнцүү байна.

2014-2015 онуудад ГФН (HFC)-ийн төрлийн бодис агуулаагүй /Ingalypt, Olazol, Airflusol forspiro 50 MCE/250MCG, Novopulmon 200dos/ ингляторыг импортлосон.

Хүснэгт 3.12. MDI импортлогчид болон MDI-д агуулагдаж буй HFC-134a бодисын агууламж

Импортлогчид	MDI-н нэр	MDI-н импортын хэмжээ, ширхэг		MDI дахь HFC-134a бодисын хэмжээ, гр	MDI дахь HFC-134a бодисын хэмжээ, кг		Нийт хэмжээ, кг
		2012	2013		2012	2013	
Ази Фарм ХХК	Вентолин 200мкг/доз-200доз	2500		0.018	45		45
Монос Фарм Трейд ХХК	Вентолин 200мкг/доз-200доз	14500	19900	0.018	261	358.2	619.2
	Фликсотид 250мкг-60доз	100		0.008	0.8		0.8
Нийт, кг					306.8	358.2	665
Нийт, тн					0.3068	0.3582	0.665

Тайлбар: MDI-Metered dose inhalers

Хүснэгт 3.13. Аерозолын салбарт ашиглагдаж буй бодисуудын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар		Бодисын төрөл	Бодисын хэмжээ, тн			Нийт / CO ₂ экв тн/
			2012	2013	Нийт	
Аерозол	Эмнэлэгийн	HFC-134a	0.3068	0.3582	0.665	950.95
	Техникийн	-	-	-	-	-
	Энгийн хэрэглээний	-	-	-	-	-

3.2.6. Гал унтраах хэрэгслүүд

Гал унтраах зориулалтаар HFC-125 бодис 1.026тн буюу 6.83%, R-744 бодис 13.975тн буюу 93.17% хэмжээтэй ашиглагдсан байна.

Гал унтраах зориулалтаар 2012-2015 онд ашиглагдсан бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв-аар илэрхийлвэл 3604.975тн хэмжээтэй тэнцүү байна. Үүний 99.6% нь HFC-25 бодис, 0.4% нь R-744 бодис байна.

Хүснэгт 3.14. Гал унтраах хэрэгсэл импортлогч ААНБ-ууд, ашигладаг бодисын нэр, төрөл

№	ААНБ-ын нэр	Бодисын нэр, төрөл
1	“Гал импекс” ХХК	R-744
2	“VTI technology” ХХК	HFC-125
3	“Боомын өндөр” ХХК	R-744
4	“Универсал авто комплекс” ХХК	R-744, ABC нунтаг
5	“ЦБОН” ХХК	C3LTD, C6LTD маркын гал унтраагуур
6	“Fire safety equipment” LLC	R-744, ABC нунтаг
7	“Fire Stop” LLC	R-744, N ₂ нунтаг гал унтраагуур

Хүснэгт 3.15. Гал унтраах зориулалтаар ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн /2012-2015/

Дэд салбар	Бодисын төрөл	Бодисын хэмжээ, тн					Нийт /CO ₂ экв тн/
		2012	2013	2014	2015	Нийт	
Гал унтраах хэрэгсэл	HFC-125		1.026			1.026	3591
	R-744	2.92	5.62	2.915	2.52	13.975	13.975
Нийт		2.92	6.646	2.915	2.52	15.001	3604.975

3.3. Монгол Улсад импортлогдон ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ (дахин цэнэглэлт)-нд зарцуулагдсан бодисын хэрэглээ

Монгол Улсын хэмжээнд 2012-2015 онд тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд нийт 482.3тн бодис зарцуулсаны 445.75тн буюу 92.4%-ийг хөргөлтийн салбарт, 29.69тн буюу 6.2%-ийг агааржуулалтын салбарт, үлдсэн 6.87тн буюу 1.4%-ийг аерозол, хөөс, гал унтраах хэрэгслийн салбарт тус тус ашигласан байна.

Хүснэгт 3.16. Монгол Улсад импортлогдон ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ (дахин цэнэглэлт)-нд зарцуулагдсан бодисын хэрэглээ

	Салбар	Бодис	Тоног төхөөрөмжид ашиглагдаж буй бодисын хэрэглээ, тн	Ялгарлын фактор, %	Засвар үйлчилгээнд зарцуулагдсан бодисын хэрэглээ, тн
Хөргөлт	Ахуйн хөргөлт	R-600a	8.39	0.1	0.00839
		HFC-134a	13.368		0.013368
		R-602	0.0006		0.00
		R-600	0.0076		0.00
		R-413A	0.0001		0.00
		R-601a	0.0071		0.00
	Худалдааны хөргөлт	R-600a	3.706	10	0.37
		HFC-134a	4.5484		0.45
		R-744	1661.673		166.17
		R-404A	7.215		0.7215
		R-410A	0.00046		0.000046
		R-170	0.00552		0.000552
		R-508B	0.0144		0.00144
		R-508A	0.00125		0.000125
		R-507	0.03538		0.003538
		R-764	2.208		0.2208
	R-704	2674.156	267.42		
	Томоохон хөргөлтийн системүүд	R-404A	0.327	10	0.0327
		R-717	95		9.5
		R-507	2.178		0.2178
Хөргөлттэй тээвэр	HFC-134a	0.368	15	0.0552	
Үйлдвэрийн чиллер	HFC-134a	0.1283	7	0.01	
	R-717	8		0.56	
Агааржуулалт	Өрөөний агааржуулалт	R-410A	17.826	1	0.17826
		R-407C	0.011		0.00011
	Бусад агааржуулалт	R-410A	1.351		0.01351
		R-407C	0.036		0.00036
		HFC-134a	22.935	0.22935	
	Чиллер	R-410A	0.224	2	0.00448
		R-407C	1.2		0.024
Автомашинны агааржуулалт	HFC-134a	292.42	10	29.242	

Аерозол	Эмнэлэгийн	HFC-134a	0.665	50	0.3325
Хөөс	Полистирол шахмал хавтан	HFC-152a	2.5	25	0.625
		R-744	17.1		4.275
		R-290	2.8		0.7
		DME	2.5		0.625
Гал унтраах хэрэгсэл		R-744	13.975	2	0.2795
		HFC-125	1.026		0.02
Нийт			4857.91		482.30

Тайлбар: “2006. IPCC guidelines for national greenhouse gas inventory” бичиг баримтын 7-р бүлэгт тусгаасан ялгарлын факторын үзүүлэлтийг ашигласан.

3.4. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC) болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын нийт хэрэглээ

Монгол Улсын хэмжээнд 2012-2015 онд ашиглагдсан нийт 5340.21тн бодисын хэрэглээг тухайн бодисын ДДНЧ-аас хамааруулан CO₂ экв тн-оор илэрхийлбэл 613225.78тн хэмжээтэй тэнцүү байна. ГФН (HFC) болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодис нь 2012 онд 574.95тн, 2013 онд 570.1тн, 2014 онд 841.16тн, 2015 онд 3353.7тн хэмжээтэй тус тус ашиглагдсан ба уг хэрэглээг CO₂ экв тн хэмжээгээр илэрхийлбэл 2012 онд 278601.6тн, 2013 онд 159264.9тн, 2014 онд 114753.2тн, 2015 онд 60606.01тн хэмжээтэй тэнцүү.

Хүснэгт 3.17. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын 2012-2015 оны нийт хэрэглээ, нийт CO₂ экв тн хэмжээ/салбар болон бодисын төрлөөр/

Хэрэглээний салбар	Бодис	Тоног төхөөрөмжид ашиглагдаж буй бодисын хэрэглээ		Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд ашиглагдаж буй бодисын хэрэглээ		Нийт хэрэглээ, тн	Нийт CO ₂ экв тн
		Бодисын хэрэглээ, тн	CO ₂ экв тн	Бодисын хэрэглээ, тн	CO ₂ экв тн		
Хөргөлт	R-600a	12.096	36.29	0.380	1.14	12.476	37.43
	HFC-134a	18.4127	26330.16	0.530	757.90	18.943	27088.06
	R-404A	7.542	29579.72	0.754	2957.97	8.296	32537.70
	R-744	1661.673	1661.67	166.170	166.17	1827.84	1827.84
	R-410A	0.00046	0.96	0.00	0.10	0.001	1.06
	R-170	0.00552	0.03	0.00	0.00	0.006	0.04
	R-508B	0.0144	192.93	0.00	19.29	0.016	212.22
	R-508A	0.00125	16.75	0.00	1.67	0.001	18.42
	R-507	2.21338	8820.32	0.221	882.03	2.435	9702.35
	R-717	103	0	10.060	0	113.06	0.00
	R-602	0.0006		0.0	0.0	0.001	0.00
	R-600	0.0076	0.0304	0.0	0.0	0.008	0.03
	R-413A	0.0001	0.21	0.0	0.0	0.21	0.21
	R-601a	0.0071	0.1775	0.0	0.0	0.007	0.18
	R-764	2.208	0	0.221	0	2.429	0.00
R-704	2674.16	0	267.416	0	2941.57	0.00	
Агааржуулалт	R-410A	19.40	40509.29	0.196	409.77	19.597	40919.06
	R-407C	1.25	2212.18	0.024	43.41	1.271	2255.59
	HFC-134a	315.36	450957.65	29.471	42144.03	344.826	493101.68
Аерозол	HFC-134a	0.665	950.95	0.333	475.48	0.998	1426.43
Хө	HFC-152a	2.5	310	0.625	77.50	3.125	387.50

	R-744	17.1	17.1	4.275	4.28	21.375	21.38
	R-290	2.8	9.24	0.700	2.31	3.500	11.55
	DME	2.5		0.625	0.00	3.125	0.00
Гал унтраах хэрэгсэл	R-744	13.975	13.975	0.280	0.28	14.255	14.25
	HFC-125	1.026	3591	0.021	71.82	1.047	3662.82
Нийт		4857.91	565210.63	482.30	48015.15	5340.21	613225.78

Хүснэгт 3.18. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын нийт хэрэглээ, он тус бүрээр /салбар болон бодисын төрлөөр/

	Салбар	Бодис	Хугацаа, он				Нийт хэрэглээ, тн	
			2012	2013	2014	2015		
Хөргөлт	Гэр ахуйн хөргөлт	R-600a	2.042	3.363	1.972	1.021	8.398	
		HFC-134a	4.374	3.964	3.702	1.340	13.38	
		R-602	0	0.0002	0.0004	0	0.001	
		R-600	0	0.0009	0.0042	0.0025	0.008	
		R-413A	0	0.0001	0	0	0.0001	
		R-601a	0	0.0071	0	0	0.007	
	Худалдааны хөргөлт	R-600a	1.199	1.793	0.693	0.392	4.077	
		HFC-134a	0.370	2.606	1.235	0.793	5.003	
		R-744	34.46	25.098	727.76	1040.52	1827.84	
		R-404A	6.710	0.3311	0.549	0.347	7.937	
		R-410A	0	0.0005	0	0	0.001	
		R-170	0	0.00077	0.00156	0.00374	0.006	
		R-508B	0	0.0003	0	0.0155	0.016	
		R-508A	0	0	0.00138	0	0.001	
		R-507	0.00011	0	0	0.0388	0.039	
		R-764	1.346	0	0	1.082	2.429	
	R-704	297	397.14	21.38	2226.05	2941.57		
	Томоохон хөргөлтийн системүүд	R-404A	0.308	0.0149	0.0033	0.0336	0.360	
		R-717	39.292	18.81	4.180	42.218	104.50	
		R-507	1.505	0.713	0.016	0.162	2.396	
	Хөргөлттэй тээвэр	HFC-134a	0.140	0.193	0.089	0	0.423	
	Үйлдвэрийн хөргөлт	HFC-134a	0	0.137	0	0	0.137	
		R-717	0	8.56	0	0	8.56	
	Агааржуулалт	Тасалгааны агааржуулалт	R-410A	9.609	2.930	4.915	0.550	18.00
			R-407C	0	0	0.001	0.01	0.011
		Бусад агааржуулалт	R-410A	0.394	0.301	0.492	0.178	1.365
R-407C			0.0033	0	0.0101	0.0229	0.036	
HFC-134a			0	1.954	21.21	0	23.16	
Чиллер		R-410A	0	0.024	0.204	0	0.228	
		R-407C	0	0	0	1.224	1.224	
Автомашинны агааржуулалт	HFC-134a	151.38	91.70	43.44	35.15	321.66		

Аерозол	Эмнэлэг	HFC-134a	0.460	0.537	0	0	0.998
Хөөсөнцөр	Полистирол шахмал хавтан	HFC-152a	0	0	3.125	0	3.125
		R-744	21.38	0	0	0	21.38
		R-290	0	0	3.5	0	3.5
		DME	0	3.125	0	0	3.125
Гал унтраах хэрэгсэл	R-744	2.98	5.73	2.97	2.57	14.26	
	HFC-125	0	1,05	0	0	1.047	
Нийт хэрэглээ, тн			574.95	570.1	841.46	3353.72	5340.21

Хүснэгт 3.19. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын нийт хэрэглээ, он тус бүрээр /бодисын төрлөөр/

№	Бодис	2012	2013	2014	2015	Нийт хэрэглээ, тн	Нийт CO ₂ экв тн
1	HFC-134a	156.72	101.09	69.676	37.283	364.77	521616.18
2	HFC-125	0	1.047	0	0	1.047	3662.82
3	HFC-152a	0	0	3.125	0	3.125	387.5
4	R-404A	7.018	0.3459	0.5523	0.3806	8.297	32538.09
5	R-407C	0.0033	0	0.0111	1.2569	1.271	2255.59
6	R-410A	10.003	3.2555	5.611	0.728	19.598	40920.12
7	R-413A	0	0.0001	0	0	0.0001	0.206
8	R-508A	0	0	0.00138	0	0.001	18.42
9	R-508B	0	0.0003	0	0.0155	0.016	211.82
10	R-507	1.505	0.713	0.016	0.201	2.435	9702.35
Нийт		175.25	106.45	78.99	39.87	400.56	611313.1
11	R-170 /Этан/	0	0.00077	0.00156	0.00374	0.006	0.036
12	R-601a /Изо-бутан/	0	0.0071	0	0	0.007	0.178
13	R-602 /Гексан/	0	0.0002	0.0004	0	0.001	0
14	R-290 /Порпан/	0	0	3.5	0	3.5	11.55
15	R-600a /Бутан/	3.241	5.156	2.665	1.413	12.48	37.425
16	R-600 /Изо-Бутан/	0	0.0009	0.0042	0.0025	0.008	0.03
17	R-744 /Нүүрсхүчлийн диоксид/	58.822	30.828	730.73	1043.09	1863.47	1863.71
18	R-717 /Аммиак/	39.292	27.37	4.18	42.218	113.06	0
19	R-764 /Хүхрийн диоксид/	1.346	0	0	1.082	2.428	0
20	R-704 /Гелий/	297	397.14	21.38	2226.05	2941.57	0


2 1	DME/Диметил эфир/	0	3.125	0	0	3.125	0
Нийт		399.70	463.63	762.46	3313.86	4939.65	1912.929
Нийт, тн		574.95	570.1	841.45	3353.72	5340.21	613225.7 8

Хүснэгт 3.20. Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын 2012-2015 оны нийт хэрэглээ, нийт CO₂ экв тн хэмжээ (нэгтгэсэн дүн)


Хэрэглээний салбар	Нийт бодисын хэрэглээ, тн	Нийт CO ₂ экв тн
Хөргөлт	4927.094	71425.54
Агааржуулалт	365.694	536276.3
Аерозол	0.998	1426.43
Хөөсөнцөр	31.125	420.43
Гал унтраах хэрэгсэл	15.302	3677.07
Нийт	5340.21	613225.78




Зураг 3.1. Монгол Улсад ашиглагдаж буй нийт ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын CO₂ экв хэмжээ, тн /2012-2015/



Зураг 3.2. ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудын хэрэглээ, тн /2012–2015/



Зураг 3.3. ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээ, тн /2012-2015/



Зураг 3.4. ГФН (НFC)-ийн төрлийн бодисуудын хэрэглээ, салбараар, тн /2012-2015/

Хүснэгт 3.21.Монгол Улсад ашиглагдаж буй ГФН (HFC)-ийн төрлийн дан болон хольц бодисуудын CO₂ экв хэмжээ, тн /2012-2015/

Хэрэглээний дэд салбар	ГФН (HFC)-ийн төрлийн бодисууд										Нийт	Нийт
	HFC-134a	R-413A	R-404A	R-410A	R-508B	R-508A	R-507	R-407C	HFC-152a	HFC-125		
	тн	тн	тн	тн	тн	тн	тн	тн	тн	тн	тн	CO ₂ экв тн
Гэр ахуйн хөргөлт	13.381	0.0001									13.38	19135.04
Худалдааны хөргөлт	5		7.937	0.00051	0.01584	0.00138	0.0389				12.99	38665.71
Томоохон хөргөлтийн систем			0.36				2.4				2.76	10975.92
Хөргөлттэй тээвэр	0.42										0.42	600.6
Үйлдвэрийн чиллер	0.137										0.137	195.91
Өрөөний агааржуулалт				18				0.011			18.011	37603.51
Бусад агааржуулалт	23.16			1.365				0.036			24.561	36032.78
Чиллер				0.23				1.224			1.454	2651.62
Автомашинны агааржуулалт	312.66										312.66	447103.8
Аэрозол	0.998										0.998	1427.14
Полистирол шахмал хавтан									3.125		3.125	387.5
Гал унтраах хэрэгсэл										1.046	1.046	3661
Нийт, тн	355.756	0.0001	8.297	19.596	0.01584	0.00138	2.4389	1.271	3.125	1.046	391.55	598440.53

Тайлбар: Энэхүү хүснэгтэнд зөвхөн ГФН (HFC)-ийн төрлийн дан болон хольц бодисуудын хэрэглээнээс ялгарах CO₂ экв тн хэмжээг харуулсан болно. ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын тооцоог Бүлэг 3.4 дэх нэгдсэн хүснэгтэнд тусгасан болно.

4. МОНГОЛ УЛСАД АШИГЛАГДАЖ БУЙ ГФН (HFC)-ҮҮД БОЛОН ДДНЧ (GWP) БАГАТАЙ ОРЛУУЛАХ БОДИСУУДЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ

Дэд бүлэг 4.1 болон 4.2 хэсэгт ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээний өсөлт болон тухайн хэрэглээний өсөлттэй тэнцэхүйц CO₂ экв тн хэмжээг тооцож харуулав.

4.1. ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээний өсөлт

ГФН (HFC)-үүд болон ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисын хэрэглээний өсөлт нь хүн амын өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, импортлогч, хэрэглэгч нарын эрэлт хэрэгцээтэй шууд хамааралтай бөгөөд судалгааны явцад авсан санал асуулгын дүнгээр бодисын хэрэглээ өсөх хандлагатай нь ажиглагдсан (Хавсралт 4-6-д тусгав).

2030 он гэхэд ГФН (HFC)-ийн төрлийн бодисуудын хэрэглээ өмнөх оны хэрэглээнээс 10-110%-иар өсч 413.89тн, ДДНЧ (GWP) багатай орлуулах бодисуудын хэрэглээ өмнөх оны хэрэглээнээс 0-20%-иар өсч 16988.9тн болж нэмэгдэх хандлагатай байна.

2030 хүртэлх бодисын өсөлтийг хэрэглээний дэд салбараар нь авч үзвэл худалдааны салбарын өсөлт 93.71%, томоохон хөргөлтийн системийн өсөлт 3.54%, бусад дэд салбаруудын өсөлт 2.75%-ийг эзлэх хандлагатай байна.

Монгол Улсын хэмжээнд 2012-2015 онд ОЗБ-ыг орлуулах бодисыг хамгийн их хэмжээтэй ашиглаж буй салбар бол худалдааны хөргөлт болон агааржуулалтын салбар бөгөөд энэ нь Монгол Улсын барилга, бүтээн байгуулалт, худалдаа үйлчилгээний салбарын эрчимтэй хөгжил, дэвшилтэй салшгүй холбоотой. Мөн ОЗБ-ыг орлуулах бодисын хэрэглээ хөдөө орон нутгийг бодвол нийслэл Улаанбаатар хотод хамгийн их байх ба цаашид томоохон худалдааны төвүүд, сүлжээ дэлгүүрүүд, нийтийн хоолны газрууд мөн худалдаа, үйлчилгээг нэгтгэсэн цогцолбор төвүүд, зочид буудлууд, оффисын зориулалтай барилгуудын бүтээн байгуулалтын ажил эрчимтэй явагдаж байгаатай холбоотойгоор хөргөлт, агааржуулалтын салбар дахь ОЗБ-ыг орлуулах бодисын хэрэглээ өсөх хандлагатай юм.


